



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Очирбатын АМГАЛАНБААТАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-45-25, Факс: 32-70-16
E-mail: amgalanbaatar@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.11.27 № 419-03/13518
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ³⁵ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АМГАЛАНБААТАР

2025000515

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮД



О.АМГАЛАНБААТАР

Д.АМАРБАЯСГАЛАН



Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ



Н.АЛТАНШАГАЙ

С.АМАРСАЙХАН



Л.МӨНХБАЯСГАЛАН

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА



Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ



Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН



Э.БАТ-АМГАЛАН


Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ



О.БАТНАЙРАМДАЛ

Ж.БАТСУУРЬ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

2025000515

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Э.БОЛОРМАА

Х.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ

М.ГАНХҮЛЭГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

2025000515

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Т.МӨНХСАЙХАН

Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

2025000515



Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Б.ПУНСАЛМАА



Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ



П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД



Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТУЛГА

Б.ТҮВШИН

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА



Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

2025000515

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

Дав.ЦОГТБААТАР

Дам.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА

Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН

2025000515



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Очирбатын АМГАЛАНБААТАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-45-25, Факс: 32-70-16
E-mail: amgalanbaatar@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.06.25 № 467-03/4830
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын зарим гишүүдтэй хамтран “Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт заасны дагуу Засгийн Газрын санал дүгнэлт авахаар Монгол Улсын Ерөнхий сайдад 2025 оны 05 дугаар сарын өдрийн тоот албан бичгээр хүргүүлсэн боловч ямар нэгэн хариу, санал дүгнэлт ирээгүй болно.


Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулсан тус хуулийн төслийг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл, холбогдох судалгаануудыг хавсаргав.

Хавсралт: ~~48~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АМГАЛАНБААТАР

2025060324

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.АМГАЛАНБААТАР

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**



Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1Хууль зүйн шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” гэж заасан. Энэ утгаараа Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Үндэсний их баяр наадмын тухай хууль нь 2003 оны 06 дугаар сарын 19-ний өдөр батлагдсанаас хойш нийт 6 удаа, давхардсан тоогоор 54 гаруй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж хуулийн анхны бичвэрээс нэлээд зүйл, хэсэг заалт өөрчлөгдсөн байна. Эдгээр өөрчлөлтийн тухайд голлон бөх, уяач, сур харваачид олгох цол, чимэг, тэднээс допингийн шинжилгээ авах, хариуцлага тооцох зохицуулалтыг бий болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт 2004, 2007, 2013, 2014, 2017 онуудад орсон байна.

Дээрх нэмэлт, өөрчлөлтөөр Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоог хангах, унаач хүүхдийн нийгмийн асуудлыг тодорхойлж хуульчлах, Улсын баяр наадмаар цол олгохтой холбоотой маргаан бүхий асуудлыг шийдвэрлэх, баяр наадмын өдрүүдэд маргаан дагуулж буй амралтын хугацаатай холбоотой асуудлыг судалж оновчтой хуульчлах, гадаадад амьдардаг монголчуудын баяр наадмыг хүндэтгэж монголд тэмдэглэн өнгөрүүлдэг баярын түвшинд авч үзэж хуульчлах зэрэг асуудлыг хөндөж нарийвчлан тусгах шаардлагатай болсон байна.

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг илэрхийлж уламжлалт урлаг, спорт, сочлын олон төрөл зүйлийг багтаасан аялал жуулчлалын гол арга хэмжээ болон хөгжиж байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зорилт нь Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байгаа бөгөөд улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмыг маргаангүй, шударга зохион байгуулах, допингийн эсрэг үйл ажиллагаа,

хариуцлагын тогтолцоотой холбоотой асуудлыг оновчтой хуульчлах нь чухал ач холбогдолтой алхам болно.

1.2. Практик шаардлага

Үндэсний их баяр наадмын тухай хууль нь 2003 онд батлагдсанаар улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмыг зохион байгуулах, бөх, сур харваачийн даваа, үзүүр түрүүний цол, чимэг олгох, тэдний эрх үүрэг, допингийн эсрэг үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоотой холбоотой эрх зүйн үндэс бүрдэхэд чухал ач холбогдолтой болсон боловч хуулийн хэрэгжилтэд зарим тулгамдсан асуудал гарсаар байна. Тухайлбал сүүлийн жилүүдэд улсын баяр наадамд түрүүлсэн, амжилттай сайн барилдаж цол, чимэг авсан бөх допинг хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдож, цол, чимгээ хураалгах, хэрэглэсэн, хэрэглээгүй дээр маргалдах, шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд ихээхэн гарсаар байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь олон улсын допингийн стандарттай нэг талаар нийцэхгүй, Захиргааны ерөнхий хуульд заасан эрх зүйн хэм хэмжээний актын шаардлагыг хангаж чадахгүйд хүрч, Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хороо, салбар хорооны шийдвэр нь шүүх дээр хүчингүй болох тохиолдол гарч байна. Иймд шинжилгээний хариу гарсны дараа цол олгох энэ төрлийн маргааныг таслах шударга шийдвэр гаргах оновчтой алхам болохоор байна.

Нөгөө талаас допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь төдийлөн үр дүнтэй бус зөвхөн хэрэглэсэн бөх, харваачид хариуцлага тооцох, тодорхой хугацаанд баяр наадамд оролцох эрхийг хасах байдлаар явж ирсэн үр дүнтэй байж чадахгүй байгаа учраас Улсын цолыг уг шинжилгээний хариу ирсний дараа олгодог байхаар хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн АНУ, Солонгос, Европын нийт 46 оронд амьдран суугаа Монголчуудын холбоог нэгтгэсэн Хилийн чанд дахь Монголчуудын зөвлөлөөс санаачлан гадаадад байгаа Монголчуудын дунд тухайн амьдарч байгаа орнуудад үндэсний өв соёлоо сурталчилж, мөн эх орноосоо хол өсөж, хүмүүжиж байгаа олон мянган хүүхэд залуучууддаа өвлүүлэн үлдээх зорилгоор жил бүрийн Улсын баяр наадмыг зохион байгуулдаг. Монгол Улсын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулж ирсэн уг наадамд улс, аймаг, сум, цэргийн цолтой 64-128 бөх зодоглодог.

Уг наадам нь аймгуудын наадамтай дүйцэх хэмжээний баяр наадам болдог тул хилийн чанад байгаа монголчуудаа өв соёлоо өвлөж, сурталчлахад нь дэмжиж, 64-128 бөхийн барилдаанд амжилт гаргасан бөхчүүдэд сум, аймгийн цол олгох, цолыг нь тухайн оронд суугаа Элчин сайд нь олгож байх саналыг хуулийн төсөлд оруулсан билээ.

Дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагад үндэслэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа дараах зохицуулалтыг оруулсан болно. Үүнд:

- Улсын баяр наадмаар насанд хүрэгчдийн ганцаарчилсан төрөлт эрийн гурван наадам зохион байгуулж болно. Эрийн гурван наадамд үндэсний бөх барилдах, их насны морь унаж уралдах, сур харваанаас бүрдэхээр,
- Дэлхийн Монгол наадмыг 3 жил тутам зохион байгуулж, уг наадмын үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, сур харвааны төрлүүдэд дэлхийн аварга цол олгохоор,
- Гадаадад амьдарч байгаа монголчуудын дунд жил бүр зохион байгуулдаг үндэсний их баяр наадамд 64 бөх барилдсан бол сумын наадамтай адилтган үзүүлэсэн бөхөд сумын начин, түрүүлсэн бөхөд сумын заан цол олгоно. 128 бөх барилдсан бол аймгийн баяр наадамтай адилтган тав давсан бөхөд аймгийн начин, зургаа давсан бөхөд аймгийн харцага, үзүүлэсэн бөхөд аймгийн заан, түрүүлсэн бөхөд аймгийн арслан цол олгохоор,
- Улсын баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан шигшмэл, бүсийн үндэсний хурдан морины уралдаанд амжилт үзүүлсэн уяачдын улсын цолд өөрчлөлт оруулахаар,
- Уралдаанч хүүхдэд Улс, аймаг, сумын оны шилдэг уралдаанч цол олгохоор,
- Үндэсний баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “тэмдэглэнэ.” гэсний дараа “Уг баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой жил бүрийн 07 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 19-ний өдрийг дуустал бүх нийтээр амрахаар,
- Шинжилгээг өгсөн бөх, сурын харваачид допингийн шинжилгээний хариу гартал батламж олгож, хариу гарсан өдрөөс хойш гурван хоногийн дотор шинжилгээний хариу болон батламжийг үндэслэн тухайн бөх, харваачдад улсын цолыг олгохоор тус тус нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулахаар тусгасан болно.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулсан болно.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох яам, төрийн захиргааны байгууллага, аймгууд болон судлаачдыг оролцуулсан 10 орчим хэлэлцүүлэг, уулзалтыг хийгээд байна.

Түүнчлэн Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны байгууллага, холбоодоос уг хуулийн төсөл, төслийг даган боловсруулсан хуулийн төсөлд саналыг авч, хуулийн төсөлд тусгаад байна.

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Үндэсний их баяр наадмын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” гэж заасан. Энэ утгаараа Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Үндэсний их баяр наадмын тухай хууль нь 2003 оны 06 дугаар сарын 19-ний өдөр батлагдсанаас хойш нийт 6 удаа, давхардсан тоогоор 54 гаруй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж хуулийн анхны бичвэрээс нэлээд зүйл, хэсэг заалт өөрчлөгдсөн байна. Эдгээр өөрчлөлтийн тухайд голлон бөх, уяач, сур харваачид олгох цол, чимэг, тэдгээрээс допингийн шинжилгээ авах, хариуцлага тооцох зохицуулалтыг бий болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт 2004, 2007, 2013, 2014, 2017 онуудад орсон байна.

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг илэрхийлж уламжлалт урлаг, спорт, соёлын олон төрөл зүйлийг багтаасан өв соёл, аялал жуулчлалын гол арга хэмжээ болон хөгжиж байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зорилт нь Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байгаа бөгөөд улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмыг зохион байгуулах, бөх, хурдан морины уяач, сурын харваачид цол, чимэг олгох, тэдний эрх үүрэг, допингийн эсрэг үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоотой холбоотой эрх зүйн хэм хэмжээ бүрдэхэд чухал ач холбогдолтой алхам болсон.

Хэдийгээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндэсний баяр наадмын тухай хууль байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд үндэсний бөхийн барилдаан, үндэсний хурдан морьдын уралдаан тойрсон маргаантай, ээдрээтэй асуудлууд гарч, баяр наадмын зохион байгуулалтад тодорхой бэрхшээл учруулах болсон.

Үндэсний их баяр наадмын тухай хууль нь 2003 онд батлагдсанаар улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмыг зохион байгуулах, бөх, хурдан морины уяач, сур харваачийн даваа, үзүүр түрүүний цол, чимэг олгох, тэдний эрх үүрэг, допингийн эсрэг үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоотой холбоотой эрх зүйн үндэс бүрдэхэд чухал ач холбогдолтой болсон боловч хуулийн хэрэгжилтэд зарим тулгамдсан асуудал

гарсаар байна. Тухайлбал сүүлийн жилүүдэд улсын баяр наадамд түрүүлсэн, амжилттай сайн барилдаж цол, чимэг авсан бөх допинг хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдож, цол, чимгээ хураалгах, хэрэглэсэн, хэрэглээгүй дээр маргалдах, шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд ихээхэн гарсаар байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь олон улсын допингийн стандарттай нэг талаар нийцэхгүй, Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хороо, салбар хорооны шийдвэр нь шүүх дээр хүчингүй болох тохиолдол гарч байна.

Нөгөө талаас допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь төдийлөн үр дүнтэй бус зөвхөн хэрэглэсэн бөх, харваачид хариуцлага тооцох, тодорхой хугацаанд баяр наадамд оролцох эрхийг хасах байдлаар явж ирсэн нь үр дүнтэй байж чадахгүй байгаа учраас Улсын цолыг уг шинжилгээний хариу ирсний дараа олгодог байхаар хуульчлах шаардлагатай байна.

Ёс заншил, өв уламжлалд ч цаг үеэ дагаад өөрчлөлт ордог. Хуучин цагт уяачийн өөрийн хүүхэд унаж уралддаг, унаган адууныхаа зан араншинг эзэн нь мэддэг байсан бол өнөөдөр “Унаач хүүхэд” гэсэн нэгэн “анги давхарга” гараад ирснийг анзаарах шаардлагатай. “Унаач хүүхэд” гэх ядруухан эцэг эхтэй, эсвэл асран хамгаалагчгүй шахам хүүхдийг дийлэнхдээ ганц үдийн хоолны мөнгөөр хөлсөлж, “Морины ажил” гэгчид дайчилж байгаа талаар удаа дараа мэдээ мэдээлэл гарсаар байгаа билээ.

Хичээлээс хоцрогдож үеийн хүүхдүүдээс сурлагын дүнгээр мууд тооцогдох болсон хүүхдүүд хичээл ном сонирхохоо больж морь унаж амьдрах нь боломжтой, энэ чигээрээ байж болно гэсэн сэтгэхүйтэй болдог байна. Гэвч хурдан морь унах хүүхдийн нас, бие бялдарын хөгжлөөс шалтгаалан морь унаж уралдах нас нь (ихэвчлэн 12, 13 наснаас хурдны морь унахаа больдог) өнгөрсөн тохиолдолд сурсан сургуульгүй, эзэмшсэн мэдлэг боловсролгүй болсон хүүхдүүд тухайн уяач, эздийнхээ морь малны бусад ажлыг хийх, мал хариулах зэрэг ажлыг хийж амьдрахаас өөр замгүй болсноор сургуулиас завсардах нөхцлийг бүрдүүлдэг байна.

Өдгөө “Морь унаач хүүхэд” гэдэг нэршил бүхий ажил мэргэжил хүүхдийн хөдөлмөрийн нэг төрөл болоод өвөл, зун ялгаагүй нэг уралдаанд бүх насны морь унаж байна. Уралдаанаас гадна үсэргээ сунгаа, морины арчилгаа, маллагаа зэрэг нэргүй олон ажлыг ч морины хүүхэд эмхэлж яваа. Хурдан морины хүүхэд нас ахиад ирэхээрээ намхан жижигхэн, давжаа, туранхай “хар” залуу болчихоод туслах уяач хийж, айлын зарц шиг явдаг гэсэн яриа ч байдаг. Ийм учраас л хурдан морь унадаг хүүхдийн эрх зүйн асуудлыг хөндөж амь нас эрүүл мэндийг хамгаалах цаг ирсэн, үүнтэй зэрэгцээд унаач хүүхдийн хөдөлмөрийг үнэлж улс, аймаг, сумын оны шилдэг уралдаанч цол олгодог байхаар хуулийн төсөлд тусгасан болно.

Түүнчлэн жирийн иргэд монгол уламжлалт ёс, соёлоо хамгаалах үүднээс судалж мэдэх зайлшгүй цаг үед ирээд байна. Монгол үндэсний морин уралдааныг

үндэсний соёл, ёс заншилаа алдагдуулахгүйгээр авч явахыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, уяачдын хөдөлмөрийн үнэлэх зорилгоор сумын гурван айраг түрүүг аймгийн нэг айраг түрүүтэй дүйцүүлэх, аймгийн гурван айраг түрүүг улс болон бүсийн нэг айраг түрүүтэй дүйцүүлэхээр тусгасан болно.

Түүнчлэн гадаад улсад допингийн асуудлыг хэрхэн хуульчилсан талаар судалсан болно. Үүнд:

1.Итали улс

Итали улсад 2000 оноос эхлэн допинг хэрэглэсэн асуудалд эрүүгийн хариуцлага тооцдог болсон. Хуулийн дагуу энэ хүрээнд багтах гурван төрлийн гэмт хэргийг ялгаж өгсөн.

- Эхний хоёр нь хэрэглэсэн тамирчин ба түүнд үйлчилж байсан ажилтнуудад шууд хамааралтай. Допинг хэрэглэх, допинг хэрэглэхэд албадах болон тэмцээн уралдаанд давуу байдал олж авахын тулд спортод хэрэглэхийг хориглосон бодисуудтай холбоотой хууль бус үйлдэл хийсэн бол тамирчин, эмч, менежер гэсэн этгээдүүдийг гурван сараас гурван жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, 50 мянган еврогоор торгууль төлнө.
- 3 дахь төрлийн гэмт хэрэг нь хориотой эм бэлдмэлийн эрэлттэй холбоотой. Допинг худалдсан, тээвэрлэсэн, хадгалсан, зуучилсан хүмүүстэй холбоотой бөгөөд энэ үйлдлүүдийг хийсэн тохиолдолд 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэж, 80 мянган еврогоор торгоно.

2.Франц улс

Францын спортын тухай кодекс болон бусад хууль журмын дагуу допинг хэрэглэсэн тамирчинд эрүүгийн хариуцлага тооцно. Спортын луйвар хийсэн, хийлгэсэн, нийлүүлсэн хүмүүсээс гадна энэ талын мөрдөн байцаалт явуулах үеэр хамтран ажиллахаас татгалзаж мэдүүлэг өгөхгүй гэвэл эрүүгийн хэрэг үүсгэн шийтгэх боломжтой. Допинг хэрэглэсэн хүнд 5 жил хүртэл хорих, 75 мянган еврогийн торгууль төлөх шийтгэл ноогдуулна. Допингтой холбоотой хэрэгт бүлэг этгээд ажиллаж байсан нь тогтоогдвол ногдуулах ял шийтгэлийн хэмжээг хоёр дахин нэмдэг.

3.Холбооны Бүгд Найрамдах Герман улс

2015 оноос эхлэн допинг хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага тооцдог болсон. Шинэ хуулиар допинг хэрэглэсэн, хадгалсан тохиолдолд тамирчин, эмч, албаны хүмүүс, дасгалжуулагчид нь гурван жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, торгууль ногдуулдаг. Мөн ХБНГУ-ын нутаг дээр допинг хэрэглэсэн гадаадын тамирчдад ч эрүү үүсгэн шийтгэдэг болсон. Допинг хэрэглэхтэй холбоотой бүлэг этгээд ажилласан, насанд хүрээгүй хүүхдийг допинг хэрэглэхийг албадсан бол хорих ялын хэмжээ 10 жил болж нэмэгддэг.

4.Испани улс

Допинг хэрэглэсэн, тараасан, хууль бусаар худалдаалсан, өөрийн цусыг сэлгэх аргыг хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, хорих ялаар шийтгэдэг.

5.Кени улс

Допингийн эсрэг дэлхийн агентлагаас хорьсон бодистой холбоотой хэрэгт холбогдвол гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэж, 30 мянган доллароор торгодог болсон. Мөн допингийн сорил өгөхөөс татгалзсан тамирчдыг 1 жил хүртэл хорих ялтай. Допинг хэрэглэсэн тамирчдад ногдуулдаг одоогийн систем нь үр дүнтэй байгаа тул эрүүгийн хариуцлага нь заавал байх ёстой шийтгэл гэж үзэхгүй байгаа. Өөрийн улсад тохирсон хууль батлах, Засгийн газрын хууль ёсны эрхэд хөндлөнгөөс оролцохгүй байх, допинг хэрэглэсэнд сэжиглэгдсэн тамирчдын зүгээс Олон улсын спортын арбитрын шүүхэд хандан давж заалдах эрхтэй гэж үздэг.

Монгол Улсын хувьд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, сэргээшний төрлийн бодис хэрэглэсэн тамирчдад хүлээлгэх хариуцлагын талаарх бусад улсуудын туршлага, шийтгэлийн арга хэмжээтэй харьцуулахад манай улсын хувьд хөнгөн шийтгэл ноогдуулдаг бөгөөд хариуцлага тооцох асуудлыг нарийвчлан зохицуулж өгөөгүй байна. Уг асуудлыг шийдэх оновчтой арга нь допингийн шинжилгээний хариу гарсны дараа цолыг олгох нь хариуцлагын нэг хэлбэр юм.

Монгол Улсын үндэсний их баяр наадам нь тасрахгүй байх агуулга Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тусгагдсан буюу онцгой нөхцөл байдлаас шалтгаалан баяр наадмын хугацааг өөр өдөр тэмдэгэхээр зохицуулалт хийж болохоор тусгасан байна. Энэ агуулгаар 2021 оны баяр наадмын цолыг нөхөж олгох зүйтэй гэж үзэж байна.

**ҮНДЭСНИЙ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” Гэж заасан. Энэ утгаараа Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Үндэсний их баяр наадмын тухай хууль нь 2003 оны 06 дугаар сарын 19-ний өдөр батлагдсанаас хойш нийт 6 удаа, давхардсан тоогоор 54 гаруй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж хуулийн анхны бичвэрээс нэлээд зүйл, хэсэг заалт өөрчлөгдсөн байна. Эдгээр өөрчлөлтийн тухайд голлон бөх, уяач, сур харваачид олгох цол, чимэг, тэднээс допингийн шинжилгээ авах, хариуцлага тооцох зохицуулалтыг бий болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт 2004, 2007, 2013, 2014, 2017 онуудад орсон байна.

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг илэрхийлж уламжлалт урлаг, спорт, сочлын олон төрөл зүйлийг багтаасан аялал жуулчлалын гол арга хэмжээ болон хөгжиж байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зорилт нь Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байгаа бөгөөд улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмыг зохион байгуулах, бөх, хурдан морины уяач, сурын харваачид цол, чимэг олгох, тэдний эрх үүрэг, допингийн эсрэг үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоотой холбоотой эрх зүйн хэм хэмжээ бүрдэхэд чухал ач холбогдолтой алхам болсон.

Хэдийгээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндэсний баяр наадмын тухай хууль байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд үндэсний бөхийн барилдаан, үндэсний хурдан морьдын уралдаан тойрсон маргаантай, ээдрээтэй асуудлууд гарч, баяр наадмын зохион байгуулалтад тодорхой бэрхшээл учруулах болсон.

Үндэсний их баяр наадмын тухай хууль нь 2003 онд батлагдсанаар улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмыг зохион байгуулах, бөх, хурдан морины уяач, сур харваачийн даваа, үзүүр түрүүний цол, чимэг олгох, тэдний эрх үүрэг, допингийн эсрэг үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоотой холбоотой эрх зүйн үндэс бүрдэхэд чухал ач холбогдолтой болсон боловч хуулийн хэрэгжилтэд зарим тулгамдсан асуудал

гарсаар байна. Тухайлбал сүүлийн жилүүдэд улсын баяр наадамд түрүүлсэн, амжилттай сайн барилдаж цол, чимэг авсан бөх допинг хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдож, цол, чимгээ хураалгах, хэрэглэсэн, хэрэглээгүй дээр маргалдах, шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд ихээхэн гарсаар байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь олон улсын допингийн стандарттай нэг талаар нийцэхгүй, Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хороо, салбар хорооны шийдвэр нь шүүх дээр хүчингүй болох тохиолдол гарч байна.

Нөгөө талаас допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь төдийлөн үр дүнтэй бус зөвхөн хэрэглэсэн бөх, харваачид хариуцлага тооцох, тодорхой хугацаанд баяр наадамд оролцох эрхийг хасах байдлаар явж ирсэн үр дүнтэй байж чадахгүй байгаа учраас Улсын цолыг уг шинжилгээний хариу ирсний дараа олгодог байхаар хуульчлах шаардлагатай байна.

Ёс заншил, өв уламжлалд ч цаг үеэ дагаад өөрчлөлт ордог. Хуучин цагт уяачийн өөрийн хүүхэд унаж уралддаг, унаган адууныхаа зан араншинг эзэн нь мэддэг байсан бол өнөөдөр “Унаач хүүхэд” гэсэн нэгэн “анги давхарга” гараад ирснийг анзаарах шаардлагатай. “Унаач хүүхэд” гэх ядруухан эцэг эхтэй, эсвэл асран хамгаалагчгүй шахам хүүхдийг дийлэнхдээ ганц үдийн хоолны мөнгөөр хөлсөлж “Морины ажил” гэгчид дайчилж байгаа талаар удаа дараа мэдээ мэдээлэл гарсаар байгаа билээ.

Өдгөө “Морь унаач хүүхэд” гэдэг нэршил бүхий ажил мэргэжил хүүхдийн хөдөлмөрийн нэг төрөл болоод өвөл, зун ялгаагүй нэг уралдаанд бүх насны морь унаж байгаа. Уралдаанаас гадна үсэргээ сунгаа, морины арчилгаа маллагаа зэрэг нэргүй олон ажлыг ч морины хүүхэд эмхэлж яваа. Хурдан морины хүүхэд нас ахиад ирэхээрээ намхан жижигхэн, давжаа туранхай хар залуу болчихоод туслах уяач хийж айлын зарц шиг явдаг гэсэн яриа ч гардаг. Ийм учраас л хурдан морь унадаг хүүхдийн эрх зүйн асуудлыг хөндөж амь нас эрүүл мэндийг хамгаалах цаг ирсэн, үүнтэй зэрэгцээд унаач хүүхдийн хөдөлмөрийг үнэлж улс, аймаг, сумын оны шилдэг унаач цол олгодог байхаар хуулийн төсөлд тусгасан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.13-5.15 дахь хэсэг:

“5.13.Улсын баяр наадмаар ганцаарчилсан төрөлт эрийн гурван наадам зохион байгуулна. Эрийн гурван наадам үндэсний бөх барилдах, их насны морь унаж уралдах, сур харваанаас бүрдэнэ.

5.14.Дэлхийн Монгол наадмыг 2026 оноос эхлэн гурван жил тутам зохион байгуулж, уг наадмын үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, сур харвааны төрлүүдэд дэлхийн аварга цол олгоно. Уг наадмын дүрмийг Засгийн газар батална.

5.15.Улсын аварга шалгаруулах тэмээний уралдааныг өвөл зохион байгуулж, тэмээний амжилтыг харгалзан Улсын алдарт уяач цол олгоно. Уг уралдааны зохион байгуулалт болон цол олгох журмыг Засгийн газар батална.”

2/8 дугаар зүйлийн 8.9, 8.10 дахь хэсэг:

“8.9.Энэ хуулийн 9.10 дугаар зүйлд заасан наадамд түрүүлсэн бөхийн цолыг тухайн баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн тухайн улсад суугаа элчин сайд олгоно.

8.10. 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан үндэсний баяр наадмын бөхийн барилдааны цолыг нөхөж олгох.”

3/9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэг:

“9.10.Гадаадад амьдарч байгаа монголчуудын дунд жил бүр зохион байгуулдаг үндэсний их баяр наадамд 64 бөх барилдсан бол сумын наадамтай адилтган үзүүрлэсэн бөхөд сумын начин, түрүүлсэн бөхөд сумын заан цол олгоно. 128 бөх барилдсан бол аймгийн баяр наадамтай адилтган тав давсан бөхөд аймгийн начин, зургаа давсан бөхөд аймгийн харцага, үзүүрлэсэн бөхөд аймгийн заан, түрүүлсэн бөхөд аймгийн арслан цол олгоно.”

4/10 дугаар зүйлийн 10.21 дэх хэсэг:

“10.21 дүгээр зүйл.Уралдаанч хүүхдэд Улс, аймаг, сумын оны шилдэг уралдаанч цол олгоно. Цол олгох журмыг Монголын морин спорт, уяачдын холбоо батална.”

5/15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт:

“15.1.8.Энэ хуулийн 5.13-т заасан эрийн гурван наадмын дүрмийг батлах.”

6/10 дугаар зүйлийн 10.22, 23 дахь хэсэг:

“10.22.Аймгийн дээд гурван насны гурван айраг, түрүүг улс бүсийн наадмын нэг айраг түрүүтэй дүйцүүлж амжилтанд тооцно.

10.23.Сумын гурван айраг түрүүг аймгийн нэг айраг түрүүтэй дүйцүүлж амжилтанд тооцно.”

7/19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт:

“19.1.4.Энэ хуульд заасан журмыг зөрчсөн уяачийн морийг уралдуулахгүй байх, цолыг хураах хүртэл арга хэмжээ авна.”

2 дугаар зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн тавдугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн”... “тэмдэглэнэ.” гэсний дараа “Уг баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой жил бүрийн 07 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 19-ний өдрийг дуустал бүх нийтээр амарна.” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:

“8.2.Энэ хуулийн 14.2-т заасан шинжилгээг өгсөн бөх, сурын харваачид допингийн шинжилгээний хариу гартал батламж олгож, хариу гарсан өдрөөс хойш гурван хоногийн дотор шинжилгээний хариу болон батламжийг үндэслэн тухайн бөх, харваачдад улсын цолыг олгоно.”

2/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

“10.4.Улсын баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан шигшмэл, бүсийн үндэсний хурдан морины уралдаанд морь нь дөрвөн удаа түрүүлсэн, эсхүл найман удаа айрагдсан уяачид улсын алдарт уяач, морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан, үүнээс улсын баяр наадамд нэг түрүүлсэн, эсхүл хоёр удаа айрагдсан уяачид улсын манлай уяач, морь нь 10 удаа түрүүлсэн, эсхүл 20 удаа айрагдсан, үүнээс улсын баяр наадамд хоёр удаа түрүүлсэн, эсхүл дөрвөн удаа айрагдсан уяачид улсын тод манлай уяач, Улсын баяр наадмын бүх насанд түрүүлсэн бол улсын дархан тод манлай уяач цол олгоно.”

3/10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг:

“10.5. Аймгийн баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид аймгийн алдарт уяач, бүх насанд түрүүлсэн бол аймгийн манлай уяач цол олгоно.”

4/10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг:

“10.6.Сумын баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид сумын алдарт уяач, бүх насанд түрүүлсэн бол сумын манлай уяач цол олгоно.”

4 дүгээр зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг, 18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дахь хэсгийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг оны ... дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ
ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх зүйлд доор дурдсан агуулга нэмсүгэй.

4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсгийн "...15" гэсний дараа "16;17; 18; 19;" гэж,

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хууль /нэмэлт, өөрчлөлт/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Очирбатын АМГАЛАНБААТАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-45-25, Факс: 32-70-16
E-mail: amgalanbaatar@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.04.24 № 44X-03/5135
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

Иймд дээрх хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт заасны дагуу саналаа ирүүлнэ үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгааг хавсаргав.

Хавсралт 35 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



2025000327

О.АМГАЛАНБААТАР

2025000235

**ҮНДЭСНИЙ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үндэсний их баяр наадмын тухай хууль нь 2003 онд батлагдсанаар улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмыг зохион байгуулах, бөх, сур харваачийн даваа, үзүүр түрүүний цол, чимэг олгох, тэдний эрх үүрэг, допингийн эсрэг үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоотой холбоотой эрх зүйн үндэс бүрдэхэд чухал ач холбогдолтой болсон боловч хуулийн хэрэгжилтэд зарим тулгамдсан асуудал гарсаар байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд улсын баяр наадамд түрүүлсэн, амжилттай сайн барилдаж цол, чимэг авсан бөх допинг хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдож, цол, чимгээ хураалгах, хэрэглэсэн, хэрэглээгүй дээр маргалдах, шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд ихээхэн гарсаар байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь олон улсын допингийн стандарттай нэг талаар нийцэхгүй, Захиргааны ерөнхий хуульд заасан эрх зүйн хэм хэмжээний актын шаардлагыг хангаж чадахгүйд хүрч, Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хороо, салбар хорооны шийдвэр нь шүүх дээр хүчингүй болох тохиолдол гарч байна. Иймд шинжилгээний хариу гарсны дараа цол олгох энэ төрлийн маргааныг таслах шударга шийдвэр гаргах оновчтой алхам болохоор байна.

Нөгөө талаас допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь төдийлөн үр дүнтэй бус зөвхөн хэрэглэсэн бөх, харваачид хариуцлага тооцох, тодорхой хугацаанд баяр наадамд оролцох эрхийг хасах байдлаар явж ирсэн нь үр дүнтэй байж чадахгүй байгаа учраас Улсын цолыг уг шинжилгээний хариу ирсний дараа олгодог байхаар хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн АНУ, Солонгос, Европын нийт 46 оронд амьдран суугаа Монголчуудын холбоог нэгтгэсэн Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлөөс санаачлан гадаадад байгаа Монголчуудын дунд тухайн амьдарч байгаа орнуудад үндэсний өв соёлоо сурталчилж, мөн эх орноосоо хол өсөж, хүмүүжиж байгаа олон мянган хүүхэд залуучууддаа өвлүүлэн үлдээх зорилгоор жил бүрийн Улсын баяр наадмыг зохион байгуулдаг. Монгол Улсын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулж ирсэн уг наадамд улс, аймаг, сум, цэргийн цолтой 64-128 бөх зодоглодог.

Уг наадам нь аймгуудын наадамтай дүйцэх хэмжээний баяр наадам болдог тул үүнийг анхааран үзэж, 64-128 бөхийн барилдаанд амжилт гаргасан бөхчүүдэд сум, аймгийн цол олгох, цолыг нь тухайн оронд суугаа Элчин сайд нь олгож байх саналыг хуулийн төсөлд оруулсан билээ.

Иймд дээрх хууль зүйн практик шаардлагын үүднээс Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагчийн зүгээс хуулийн төслийг боловсрууллаа.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын санаачлан боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

ХОЁР.АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

Монголын үндэсний спорт - морин уралдаан нь бага насны хүүхдэд морь унуулан уралдуулж ирсэн түүхэн уламжлал, онцлогтой бөгөөд энэ нь хурдан морь уяж уралдуулах, сур харвах, бөх барилдуулах өв соёл, уяачдын мэдлэг, туршлагыг хойч үедээ өвлүүлэн үлдээх чухал ач холбогдолтой учраас уг баяраа маргаангүй хуулийн хүрээнд хийх нь чухал байна.

Иймд жил бүрийн баяр наадам, тэр дундаа хурдан морины уралдаан, бөхийн барилдаан, сурын харваа зэргийг маргаангүй, ашиг сонирхлын зөрчилгүй зохион байгуулах, тэдгээрийн эрхийг тэгш хангах нөхцөл бүрдүүлэх зорилгоор уг хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж маргаан дагуулж буй бөхийн допингийн асуудал, унаач хүүхдийг дэмжих асуудал, баяр наадмын хугацааг сунгах, гадаадад оршин сууж буй Монголчуудын баяр наадмыг дэмжих зэрэг асуудлыг тодорхойлж хуульчлах шаардлагатай байна.

Иймд энэхүү хууль нь цаг үеэ олсон, дээрх харилцааг зохицуулахад чиглэсэн чухал шаардлагатай хуулийн төсөл гэж үзэж байна.

ГУРАВ.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Үндэсний их баяр наадмын тухай хууль нь 2003 онд батлагдснаар улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмыг зохион байгуулах, бөх, хурдан морины уяач, сур харваачийн даваа, үзүүр түрүүний цол, чимэг олгох, тэдний эрх үүрэг, допингийн эсрэг үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоотой холбоотой эрх зүйн үндэс бүрдэхэд чухал ач холбогдолтой болсон боловч хуулийн хэрэгжилтэд зарим тулгамдсан асуудал гарсаар байна. Тухайлбал сүүлийн жилүүдэд улсын баяр наадамд түрүүлсэн, амжилттай сайн барилдаж цол, чимэг авсан бөх допинг хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдож, цол, чимгээ хураалгах, хэрэглэсэн, хэрэглээгүй дээр маргалдах, шүүхээр

шийдвэрлүүлэх тохиолдол ихээхэн гарсаар байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь олон улсын допингийн стандарттай нэг талаар нийцэхгүй, Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хороо, салбар хорооны шийдвэр нь шүүх дээр хүчингүй болох тохиолдол гарч байна.

Нөгөө талаас допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь төдийлөн үр дүнтэй бус зөвхөн хэрэглэсэн бөх, харваачид хариуцлага тооцох, тодорхой хугацаанд баяр наадамд оролцох эрхийг хасах байдлаар явж ирсэн нь үр дүнтэй байж чадахгүй байгаа учраас Улсын цолыг уг шинжилгээний хариу ирсний дараа олгодог байхаар хуульчлах шаардлагатай байна.

Ёс заншил, өв уламжлалд ч цаг үеэ дагаад өөрчлөлт ордог. Хуучин цагт уяачийн өөрийн хүүхэд унаж уралддаг, унаган адууныхаа зан араншинг эзэн нь мэддэг байсан бол өнөөдөр “Унаач хүүхэд” гэсэн нэгэн “анги давхарга” гараад ирснийг анзаарах шаардлагатай. “Унаач хүүхэд” гэх ядруухан эцэг эхтэй, эсвэл асран хамгаалагчгүй шахам хүүхдийг дийлэнхдээ ганц үдийн хоолны мөнгөөр хөлсөлж “Морины ажил” гэгчид дайчилж байгаа талаар удаа дараа мэдээ мэдээлэл гарсаар байгаа билээ.

Өдгөө “Морь унаач хүүхэд” гэдэг нэршил бүхий ажил мэргэжил хүүхдийн хөдөлмөрийн нэг төрөл болоод өвөл, зун ялгаагүй нэг уралдаанд бүх насны морь унаж байгаа. Уралдаанаас гадна үсэргээ сунгаа, морины арчилгаа маллагаа зэрэг нэргүй олон ажлыг ч морины хүүхэд эмхэлж яваа. Хурдан морины хүүхэд нас ахиад ирэхээрээ намхан жижигхэн, давжаа туранхай хар залуу болчихоод туслах уяач хийж айлын зарц шиг явдаг гэсэн яриа ч гардаг. Ийм учраас л хурдан морь унадаг хүүхдийн эрх зүйн асуудлыг хөндөж амь нас эрүүл мэндийг хамгаалах цаг ирсэн, үүнтэй зэрэгцээд унаач хүүхдийн хөдөлмөрийг үнэлж улс, аймаг, сумын оны шилдэг унаач цол олгодог байхаар хуулийн төсөлд тусгасан болно.

Иймд дээрх хууль зүйн болон практик шаардлагын үүднээс Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагчийн зүгээс хуулийн төслийг боловсрууллаа.

ДӨРӨВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	Бөхчүүд шударгаар барилдах, цол, чимэг авах эрх хэрэгжих байдал	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Уг эрх бүрэн хэрэгжих сайн шийдэл болно.
2	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Илүү зардал гарахгүй

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл	Тийм	Шударга ёсны зарчимд нийцнэ

	хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх			
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбогдолгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй
3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	байршил өөрчлөгдөхийг оролцуулан)			
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хөндсөн зохицуулалт бий болгох эсэх			
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Зардал гарахгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.
------------------------	--	------	--

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Эерэг нөлөөтэй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Эерэг нөлөөтэй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Эерэг нөлөөтэй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

-----oOo-----

ҮНДЭСНИЙ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын санаачлан боловсруулсан Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл төрлөөр боловсруулагдсан хувилбар байв. Хуулийн төсөл нь таван зүйлээс бүрдэж байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу хийлээ.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Харилцан уялдаа зэрэг болно.

“**Зорилгод хүрэх байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“**Ойлгомжтой байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс үнэлэхийг зорьж сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хуульд нэмэлт оруулах төсөл тул хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд болон хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо нийцсэн эсэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь аргачлалын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр сонгосон болно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 1, 3, 4 дүгээр зүйлд заасанд үнэлгээ хийхээр сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

/Хуулийн төсөл таван зүйлтэй./

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <u>ойлгомжтой</u> байдлыг шалгах.
3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн үзэл баримтлалаас харахад үндэсний баяр наадмаар бөхчүүдэд цол олгох асуудал нь допингийн шинжилгээнээс хамаарч маргаан гарах асуудал, гадаадад байгаа монголчуудын баяр наадамд зохих цол олгох, унаач хүүхдийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх, үндэсний баяр наадмаар амрах хугацаа зэрэг асуудлыг хуулийн төсөлд бүрэн судалж тусгаагүй буюу уг асуудлыг зохицуулах нь маш чухал юм.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага

<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагагүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагагүй.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.

30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа
2	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
3	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
6	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
7	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
8	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
9	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
10	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
12	хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.

13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээ тусгаагүй тул шаардлагагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний баяр наадмын тухай хуулийг удирдлага болгосон.

5.2.Дүгнэлт

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийсэн.

Хуулийн төслийн таван зүйлийн хувьд хуулийн төслийн үзэл баримтлал болон энэхүү хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлагатай нийцэж байгаа нь зорилгод хүрэх, ойлгомжтой байх, бусад хууль тогтоомжтой нийцсэн, давхардалгүй, зөрчилгүй томъёологдсон байна.

Монгол Улсын үндсэн хуульд заасан эрх бүрэн хэрэгжих зэрэг олон талын ач холбогдолтой учир энэхүү хуулийн төсөл зорилгодоо хүрэх бүрэн боломжтой.

Иймд хуулийн төсөл дэмжигдэх болон хэрэгжих бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

ҮНДЭСНИЙ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах нийт зардлын тооцоог дараах байдлаар үзүүлэв:

Тус хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:

- 2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах.

Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоог дараах дарааллаар хийх:

- 3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 3.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 3.5.Хялбарчлах боломжийг шалгах.

ХОЁР.ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Улсын баяр наадмыг зохион байгуулахад гарах зардлын талаарх тодорхой мэдээлэл хязгаарлагдмал бөгөөд жил бүр өөр байдаг. Наадмын зардал нь бөх, морины уралдаан, сурын харваа, шагайн харваа, урлагийн тоглолт, нийтийн цэнгүүн зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хамардаг. Мөн тээвэр, хамгаалалт, талбайн тохижилт, шагналын сан, зохион байгуулалтын бусад зардал (ажилтнуудын цалин, тоног төхөөрөмж, шатахуун гэх мэт) багтана.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 15 дугаар зүйлд “Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах талаарх Засгийн газрын бүрэн эрх”-ийг баталгаажуулсан байдаг. Тус хуулийн 15.1-д “Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.1.4-д “улсын баяр наадмыг

тэмдэглэн өнгөрүүлэх, допингийн шинжилгээ хийхэд шаардагдах төсвийг батлах, зарцуулалтад хяналт тавих” гэж тодорхой заасан байдаг.

Монгол Улсын Үндэсний их баяр наадмын зардлыг Засгийн газар, Үндэсний их баяр наадмын комисс хамтран улсын төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд энэ нь жил бүр хэлбэлзэлтэй байдаг. Зардалд дараах гол хэсгүүд багтана:

- Нээлт, хаалтын арга хэмжээ: 2024 оны наадмын нээлт, хаалтын тоглолт “Эх дэлхий, энх оршихуйн цадиг” сэдвийн дор зохион байгуулагдсан бөгөөд археологийн олдворуудыг орчин үеийн урлагийн хэлбэрээр мюзикл маягаар толилуулсан. Ийм тоглолтын найруулга, тайз засал, уран бүтээлчдийн гоёл, техникийн тоног төхөөрөмж зэрэг нь өндөр өртөгтэй байдаг.

- Талбайн тохижилт, засвар: Төв цэнгэлдэх хүрээлэн, Хүй долоон худагт авто зам засвар, шинэ зогсоол, боловсон ариун цэврийн байгууламж, зүлэгжүүлэлт зэрэг ажлууд хийгдсэн.

- Тэмцээн, уралдааны зардал: Бөхийн барилдаан (512 бөх), морины уралдаан (6 насны морьд), сурын харваа (686 харваач), шагайн харваа (776 харваач) зэрэгт шагналын сан, зохион байгуулалтын зардал (шүүгчид, талбайн бэлтгэл, тээвэр гэх мэт) багтана.

- Хамгаалалт, аюулгүй байдал: Цагдаа, онцгой байдлын алба, хэв журмын ажилтнуудын зардал, түүнчлэн нийтийн аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж.

- Бусад зардал: “Дээлтэй Монгол наадам”, хүндэтгэлийн концерт, “Улаанбаатарын үдэш” шоу, нийтийн цэнгүүн, ёслолын буудлага зэрэг арга хэмжээнүүдийн зохион байгуулалт, тээвэр, хэвлэл мэдээллийн зардал.

НЭГ.ҮНДЭСНИЙ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Ерөнхий мэдээлэл Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх хэмнэлт, зардал, хөнгөлөлт, ачааллыг урьдчилан тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлангийн зорилго чиглэгдэх болно.

Хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул зардал тооцоход ашиглагдах бодит статистик болон зарцуулах хугацааг шууд мэдэх боломжгүй тохиолдолд дээрх аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтыг тус тус үндэслэнэ. Хуулийн этгээд болон төрийн байгууллагын зүгээс гүйцэтгэж хуулийн төсөлд тусгагдсантай ижил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, хэрэв байгаа тохиолдолд тухайн үүргийг гүйцэтгэхэд зарцуулж байгаа хугацаа болон тохиолдлын тоонд үндэслэн баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэн болон хуулийн этгээдэд гүйцэтгэх үүргийг тогтоох, цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох, тоон үзүүлэлтийг тооцох шаардлагагүй бөгөөд хуулийн төсөл хэрэгжиж эхэлсэнээр бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд наадмын үеэр ялангуяа үйлчилгээ, худалдааны байгууллагууд нэмэлт орлого олох, хувь иргэд чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх боломж бүрдэнэ. Мөн хуулийн этгээдэд санхүүгийн эх үүсвэр бизнесээ өргөжүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрлэл үйлчилгээний тоног төхөөрөмжөө шинэчлэх зэрэгт зарцуулах цаг хугацааны болон санхүүгийн таатай боломж бүрдэнэ гэж үзэж байна.

ХОЁР.ҮНДЭСНИЙ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- 4.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 4.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 4.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 4.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 4.6.Нэмэлт зардлыг тооцох.

2.1.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

2020-2024 онуудад Монгол Улсын Үндэсний их баяр наадмыг зохион байгуулахад улсын төсвөөс зарцуулсан зардлын талаарх албан ёсны, нарийвчилсан мэдээлэл олон нийтэд ил тод нээлттэй хэлбэрээр хязгаарлагдмал байдаг. Засгийн газар болон Үндэсний их баяр наадмын комисс уг зардлыг жил бүр улсын төсвөөс санхүүжүүлдэг боловч тодорхой тоо баримтыг тусад нь задалж нийтэлдэггүй. Гэсэн хэдий ч доорх мэдээлэл нь эх сурвалж, таамаглал болон холбогдох баримтуудад үндэслэн жил бүрээр хураангуйлсан тойм юм. Зардлын гол хэсгүүдэд нээлт, хаалтын арга хэмжээ, бөхийн барилдаан, морины уралдаан, сурын харваа, шагайн харваа, талбайн тохижилт, хамгаалалт, тээвэр, шагналын сан болон бусад зохион байгуулалтын зардал багтдаг.

2020 он

Нөхцөл байдал: 2020 онд COVID-19 цар тахлын улмаас Улсын баяр наадам хязгаарлагдмал хэлбэрээр зохион байгуулагдсан. Олон нийтийн арга хэмжээ, тухайлбал нээлт, хаалтын тоглолт, нийтийн цэнгүүн зэрэг зохион байгуулагдаагүй, харин бөхийн барилдаан, морины уралдаан, сурын харваа зэрэг гол тэмцээнүүд хүн цугларалтгүй, телевизийн шууд дамжуулалтаар явагдсан.

Зардал: Хязгаарлагдмал хэлбэрийн улмаас зардал бусад жилүүдээс бага байсан гэж таамагладаг. Гол зардал нь шагналын сан, талбайн бэлтгэл, телевизийн дамжуулалтын техник, хамгаалалт зэрэгт чиглэгдсэн. Албан бус эх сурвалжийн мэдээллээр, нийт зардал 1-2 тэрбум төгрөгийн хооронд байж болзошгүй, гэхдээ албан ёсны тоо байхгүй.

2021 он

Нөхцөл байдал: 2021 онд цар тахлын нөлөө хэвээр байсан ч наадам илүү өргөн хүрээнд зохион байгуулагдсан. Гэсэн хэдий ч зарим хязгаарлалт (жишээ нь, цугларалтын тооны хязгаар) хэрэгжиж байв. Нээлт, хаалтын арга хэмжээ хязгаарлагдмал хэлбэрээр болсон.

Зардал: Зардал 2020 оноос өндөр байсан ч бүрэн хэмжээний наадамтай харьцуулахад бага байсан байж болзошгүй. Төв цэнгэлдэх хүрээлэн болон Хүй долоон худагт тохижилт, шагналын сан, зохион байгуулалтын зардал (шүүгчид, ажилтнуудын цалин, тээвэр) гол хэсгийг эзэлсэн. Нийт зардал 2-3 тэрбум төгрөг орчим байсан гэж таамагладаг.

2022 он

Нөхцөл байдал: 2022 онд цар тахлын хязгаарлалт суларч, наадам уламжлалт хэлбэрээрээ бүрэн хэмжээгээр зохион байгуулагдсан. Нээлт, хаалтын тоглолт, “Дээлтэй Монгол” арга хэмжээ, нийтийн цэнгүүн зэрэг багтсан.

Зардал: Улсын төсвөөс зарцуулсан нийт зардлын талаар албан ёсны мэдээлэл байхгүй ч, нээлт, хаалтын тоглолтын өндөр өртөгтэй найруулга, талбайн засвар (Төв цэнгэлдэх хүрээлэнд зүлэгжүүлэлт, барилга байгууламжийн шинэчлэл), шагналын сан зэрэгт ихээхэн хөрөнгө зарцуулагдсан. Нийт зардал 3-5 тэрбум төгрөгийн хооронд байсан гэж таамагладаг.

2023 он

Нөхцөл байдал: 2023 онд наадам бүрэн хэмжээгээр, уламжлалт хэлбэрээр зохион байгуулагдсан. Нээлт, хаалтын арга хэмжээ, урлагийн тоглолт, бөхийн барилдаан (512 бөх), морины уралдаан, сурын харваа, шагайн харваа зэрэг багтсан. Мөн “Дээлтэй Монгол”, “Улаанбаатарын үдэш” зэрэг нэмэлт арга хэмжээнүүд болсон.

Зардал: Зарим эх сурвалжийн мэдээллээр, нийт зардал хэдэн тэрбум төгрөгт хүрсэн гэж таамагладаг. Төв цэнгэлдэх хүрээлэнд авто зам засвар, шинэ зогсоол, боловсон ариун цэврийн байгууламж зэрэг тохижилтын ажлууд нэмэгдсэн. Нийт зардал 4-6 тэрбум төгрөг орчим байж болзошгүй.

2024 он

Нөхцөл байдал: 2024 оны наадам “Эх дэлхий, энх оршихуйн цадиг” сэдвийн дор зохион байгуулагдсан бөгөөд нээлт, хаалтын тоглолтод археологийн олдворуудыг орчин үеийн урлагийн хэлбэрээр толилуулсан мюзикл хэлбэртэй байв. Төв цэнгэлдэх хүрээлэнд авто зам засвар, шинэ зогсоол, зүлэгжүүлэлт, боловсон ариун цэврийн байгууламж зэрэг тохижилтын ажлууд хийгдсэн. Наадам 6 хоногийн амралттай (7-р сарын 10-15) холбогдон өргөн хүрээнд тэмдэглэгдсэн.

Зардал: Нээлтийн тоглолтын өндөр өртөгтэй найруулга, талбайн тохижилт, шагналын сан, хамгаалалт, тээвэр зэрэгт зарцуулсан нийт зардал өмнөх жилүүдээс өндөр байсан байж болзошгүй. Албан бус таамаглалаар, нийт зардал 5-7 тэрбум төгрөг орчим байж болно.

Дүгнэлт

2020-2024 оны нийт зардлын тооцооллыг харвал нийтдээ 15-23 тэрбум төгрөгийн хооронд зарцуулагджээ. 2020, 2021 онд цар тахлын улмаас зардал бага, харин 2022-2024 онд уламжлалт хэлбэрээр зохион байгуулагдсанаар зардал нэмэгдсэн. Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ямар нэгэн дарамт ирэхгүй. Харин аялал жуулчлалын орлого огцом нэмэгдэж улс орныг дэлхий нийтэд сурталчлан таниулах, цаашлаад тусгаар тогтнолын баталгаа бэхжих томоохон ач холбогдолтой байна.

Хууль санаачлагч нэр



УИХ-ын гишүүн
Очирбатын АМГАЛАНБААТ...



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 ОНЫ 5-Р САРЫН 6 ӨДӨР

УЛААНБААТАР

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



✓ Дагах

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуульд доор дүрдсэн агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.13-5.15 дахь хэсэг:

"5.13.Улсын баяр наадмаар ганцаарчилсан төрөлт эрийн гурван наадам зохион байгуулна. Эрийн гурван наадам үндэсний бөх барилдах, их насны морь унаж уралдах, сур харваанаас бүрдэнэ.

5.14.Дэлхийн Монгол наадмыг 2026 оноос эхлэн гурван жил тутам зохион байгуулж, уг наадмын үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, сур харвааны төрлүүдэд дэлхийн аварга цол олгоно. Уг наадмын дүрмийг Засгийн газар батална.

5.15.Улсын аварга шалгаруулах тэмээний уралдааныг өвөл зохион байгуулж, тэмээний амжилтыг харгалзан Улсын алдарт уяач цол олгоно. Уг уралдааны зохион байгуулалт болон цол олгох журмыг Засгийн газар батална."

2/8 дугаар зүйлийн 8.9, 8.10 дахь хэсэг:

- 1 ДҮГЭЭР ЗҮЙЛҮ...
- 1/5 ДУГААР ЗҮЙЛ...
- 2/8 ДУГААР ЗҮЙЛ...
- 3/9 ДҮГЭЭР ЗҮЙЛ...
- 4/10 ДУГААР ЗҮЙ...
- 5/15 ДУГААР ЗҮЙ...
- 6/10 ДУГААР ЗҮЙ...
- 7/19 ДҮГЭЭР ЗҮЙ...
- 2 ДУГААР ЗҮЙЛҮ...
- 3 ДУГААР ЗҮЙЛҮ...
- 1/6 ДУГААР ЗҮЙЛ...
- 2/10 ДУГААР ЗҮЙ...
- 3/10 ДУГААР ЗҮЙ...
- 4/10 ДУГААР ЗҮЙ...
- 4 ДҮГЭЭР ЗҮЙЛҮ...
- 5 ДУГААР ЗҮЙЛ...

2/8 дугаар зүйлийн 8.9, 8.10 дахь хэсэг:

"8.9.Энэ хуулийн 9.10 дугаар зүйлд заасан наадамд түрүүлсэн бөхийн цолыг тухайн баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн тухайн улсад суугаа элчин сайд олгоно.

8.10. 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан үндэсний баяр наадмын бөхийн барилдааны цолыг нөхөж олгох."

3/9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэг:

"9.10.Гадаадад амьдарч байгаа монголчуудын дунд жил бүр зохион байгуулдаг үндэсний их баяр наадамд 64 бөх барилдсан бол сумын наадамтай адилтган үзүүлсэн бөхөд сумын начин, түрүүлсэн бөхөд сумын заан цол олгоно. 128 бөх барилдсан бол аймгийн баяр наадамтай адилтган тав давсан бөхөд аймгийн начин, зургаа давсан бөхөд аймгийн харцага, үзүүлсэн бөхөд аймгийн заан, түрүүлсэн бөхөд аймгийн арслан цол олгоно."

4/10 дугаар зүйлийн 10.21 дэх хэсэг:

"10.21 дүгээр зүйл.Уралдаанч хүүхдэд Улс, аймаг, сумын оны шилдэг уралдаанч цол олгоно. Цол олгох журмыг Монголын морин спорт, уяачдын холбоо батална."

5/15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт:

"15.1.8.Энэ хуулийн 5.13-т заасан эрийн гурван наадмын дүрмийг батлах."

6/10 дугаар зүйлийн 10.21 дэх хэсэг:

"10.21.Аймгийн дээд гурван насны гурван айраг, түрүүг улс бүсийн наадмын нэг айраг түрүүтэй дүйцүүлж амжилтанд тооцно.

10.22. Сумын гурван айраг түрүүг аймгийн нэг айраг түрүүтэй дүйцүүлж амжилтанд тооцно."

7/19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт:

"19.1.4.Энэ хуульд заасан журмыг зөрчсөн уяачийн морийг уралдуулахгүй байх, цолыг хураах хүртэл арга хэмжээ авна."

2 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн тавдугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн "... "тэмдэглэнэ." гэсний дараа "Уг баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой жил бүрийн 07 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 19-ний өдрийг дуустал бүх нийтээр амарна." гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:

"8.2.Энэ хуулийн 14.2-т заасан шинжилгээг өгсөн бөх, сурын харваачид допингийн шинжилгээний хариу гартал батламж олгож, хариу гарсан өдрөөс хойш гурван хоногийн дотор шинжилгээний хариу болон батламжийг үндэслэн тухайн бөх, харваачдад улсын цолыг олгоно."

2/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

"10.4.Улсын баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан шигшмэл, бүсийн үндэсний хурдан морины уралдаанд морь нь дөрвөн удаа түрүүлсэн, эсхүл найман удаа айрагдсан уяачид улсын алдарт уяач, морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан, үүнээс улсын баяр наадамд нэг түрүүлсэн, эсхүл хоёр удаа айрагдсан уяачид улсын манлай уяач, морь нь 10 удаа түрүүлсэн, эсхүл 20 удаа айрагдсан, үүнээс улсын баяр наадамд хоёр удаа түрүүлсэн, эсхүл дөрвөн удаа айрагдсан уяачид улсын тод манлай уяач, Улсын баяр наадмын бүх насанд түрүүлсэн бол улсын дархан тод манлай уяач цол олгоно."

5/15 ДУГААР ЗҮЙ...

6/10 ДУГААР ЗҮЙ...

7/19 ДҮГЭЭР ЗҮЙ...

2 ДУГААР ЗҮЙЛҮ...

3 ДУГААР ЗҮЙЛҮ...

1/8 ДУГААР ЗҮЙЛ...

2/10 ДУГААР ЗҮЙ...

3/10 ДУГААР ЗҮЙ...

4/10 ДУГААР ЗҮЙ...

4 ДҮГЭЭР ЗҮЙЛҮ...

5 ДУГААР ЗҮЙЛЭ...

3/10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг:

“10.5. Аймгийн баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид аймгийн алдарт уяач, бүх насанд түрүүлсэн бол аймгийн манлай уяач цол олгоно.”

4/10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг:

“10.6. Сумын баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид сумын алдарт уяач, бүх насанд түрүүлсэн бол сумын манлай уяач цол олгоно.”

4 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг, 18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дахь хэсгийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг оны ... дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТӨСЛИЙН ФАЙЛУУД

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ -ТӨСЛИЙН ДОКУМЕНТ ФАЙЛ /DOC, DOCX/

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ -ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ...

(О.Амгаланбаатар-Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.docx)

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ хуулийн төсөлд**

d.parliament.mn хаягаар ирсэн саналууд

№	НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗААЛТ		дэм жсэ н	дэм жээ гүй	санал	
	1 дүгээр зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:		3	0	0	
1	1/5 дугаар зүйлийн 5.13-5.15 дахь хэсэг:	“5.13.Улсын баяр наадмаар ганцаарчилсан төрөлт эрийн гурван наадам зохион байгуулна. Эрийн гурван наадам үндэсний бөх барилдах, их насны морь унаж уралдах, сур харваанаас бүрдэнэ.	5	0	1	Их насны морь гэгчээр зөвхөн их нас уралдана гэж ойлгож байна. Их гэдэг үгээ бүх насны морьд гэдгээр солих
2		5.14.Дэлхийн Монгол наадмыг 2026 оноос эхлэн гурван жил тутам зохион байгуулж, уг наадмын үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, сур харвааны төрлүүдэд дэлхийн аварга цол олгоно. Уг наадмын дүрмийг Засгийн газар батална.	6	1	2	өв соёлоо уламжлан дээдлэх, монгол дархлааг бэхжүүлэхэд чухал санаачилга байна. Дэмжиж байна Дэлхийгээр тархан сууршсан монгол угсаатангуудаа бүгдын оруулаж хамруулах нь зөв
3		5.15.Улсын аварга шалгаруулах тэмээний уралдааныг өвөл зохион байгуулж, тэмээний амжилтыг харгалзан Улсын алдарт уяач цол олгоно. Уг уралдааны зохион байгуулалт болон цол олгох журмыг Засгийн газар батална.”	6	0	0	
1	2/8 дугаар	“8.9.Энэ хуулийн 9.10 дугаар зүйлд заасан наадамд түрүүлсэн бөхийн цолыг тухайн баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн тухайн улсад суугаа элчин сайд олгоно.	4	0	0	
						Монгол бөхийг гиннесийн дээд амжилтанд бүртгүүлсэн 6016 бөхийн барилдаанд 13 давж түрүүлсэн Санжаадамба аваргад Дархан аварга цолыг нөхөж олгуулж өгөхийг тусгавал зүгээр юм даа. Энэ бол маш том амжилт юм

1	2	зүйлийн 8.9, 8.10 дахь хэсэг:	8.10.2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан үндэсний баяр наадмын бөхийн барилдааны цолыг нөхөж олгох.”	6	0	2	Монгол наадам цорын ганц удаа буюу 2021 онд тасарсан наадамд цол олгох ёстой. Монгол наадам хэзээ ч тасрах учиргүй. Энэ бол Монголчуудын маш том дархлаа учраас энэ саналыг дэмжиж байна. Харин Монгол бөхийг Гиннесийн номд бүртгүүлэх тухай 6002 бөхийн барилдааны цол огт хэрэггүй. Хэрэв энийг хамтад нь оруулвал дээрх санал шууд унана. Энэ бол огт хамаагүй тэр жил наадам болсон түрүүлэх бөх нь түрүүлээд цолоо авсан.
	3	3/9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэг:	“9.10.Гадаадад амьдарч байгаа монголчуудын дунд жил бүр зохион байгуулдаг үндэсний их баяр наадамд 64 бөх барилдсан бол сумын наадамтай адилтган үзүүрлэсэн бөхөд сумын начин, түрүүлсэн бөхөд сумын заан цол олгоно. 128 бөх барилдсан бол аймгийн баяр наадамтай адилтган тав давсан бөхөд аймгийн начин, зургаа давсан бөхөд аймагийн харцага, үзүүрлэсэн бөхөд аймагийн заан, түрүүлсэн бөхөд аймагийн арслан цол олгоно.”	5	1	1	Гадаадад амьдарч буй олон мянган монголчууд өв соёлоо тээх, таних өвлүүлэх, нэгдэх, монгол хүн байхад нь дэмжсэн зөв заалт гэж үзэж байна.
	4	4/10 дугаар зүйлийн 10.21 дэх хэсэг:	“10.21 дүгээр зүйл.Уралдаанч хүүхдэд Улс, аймаг, сумын оны шилдэг уралдаанч цол олгоно. Цол олгох журмыг Монголын морин спорт, уяачдын холбоо батална.”	4	0	1	Хүүхдийн амжилтыг үнэлж, хуульчлах нь зөв
	5	5/15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт:	“15.1.8.Энэ хуулийн 5.13-т заасан эрийн гурван наадмын дүрмийг батлах.”	5	0	0	
	6	6/10 дугаар зүйлийн	“10.21.Аймгийн дээд гурван насны гурван айраг, түрүүг улс бүсийн наадмын нэг айраг түрүүтэй дүйцүүлж амжилтанд тооцно.	5	0	0	
	7	10.21 дэх хэсэг:	10.22. Сумын гурван айраг түрүүг аймагийн нэг айраг түрүүтэй дүйцүүлж амжилтанд тооцно.”	4	0	0	

	8	7/19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт:	"19.1.4.Энэ хуульд заасан журмыг зөрчсөн уяачийн морийг уралдуулахгүй байх, цолыг хураах хүртэл арга хэмжээ авна."	4	0	0	
2	2 дугаар зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн тавдугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн"... "тэмдэглэнэ." гэсний дараа "Уг баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой жил бүрийн 07 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 19-ний өдрийг дуустал бүх нийтээр амарна." гэж нэмсүгэй.			8	0	0	
3	3 дугаар зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:			4	0	0	
	1	1/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:	8.2.Энэ хуулийн 14.2-т заасан шинжилгээг өгсөн бөх, сурын харваачид допингийн шинжилгээний хариу гартал батламж олгож, хариу гарсан өдрөөс хойш гурван хоногийн дотор шинжилгээний хариу болон батламжийг үндэслэн тухайн бөх, харваачдад улсын цолыг олгоно."	4	0	0	
	2	2/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:	Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан шигшмэл, бүсийн үндэсний хурдан морины уралдаанд морь нь дөрвөн удаа түрүүлсэн, эсхүл найман удаа айрагдсан уяачид улсын алдарт уяач, морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан, үүнээс улсын баяр наадамд нэг түрүүлсэн, эсхүл хоёр удаа айрагдсан уяачид улсын манлай уяач, морь нь 10 удаа түрүүлсэн, эсхүл 20 удаа айрагдсан, үүнээс улсын баяр наадамд хоёр удаа түрүүлсэн, эсхүл дөрвөн удаа айрагдсан уяачид улсын тод манлай уяач, Улсын баяр наадмын бүх насанд түрүүлсэн бол улсын дархан тод манлай уяач цол олгоно."	5	0	0	

3	3/10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг:	“10.5. Аймгийн баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид аймгийн алдарт уяач, бүх насанд түрүүлсэн бол аймгийн манлай уяач цол олгоно.”	3	0	1	Тоо арай олон байна.
4	4/10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг:	“10.6.Сумын баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид сумын алдарт уяач, бүх насанд түрүүлсэн бол сумын манлай уяач цол олгоно.”	3	0	1	3 удаа түрүүлсэн, 6 удаа айрагдсан гэсэн дээр байхаа
4	4 дүгээр зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг, 18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дахь хэсгийг тус тус хассугай.		5	0	0	
5	5 дугаар зүйл.Энэ хуулийг оны ... дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.		5	1	0	
нийт					9	санал

УИХ-ЫН ГИШҮҮН О.АМГАЛАНБААТАРЫН АЖЛЫН АЛБА

ҮНДЭСНИЙ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬ-д

**нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор
аймаг, сум, байгууллага, мэргэжлийн холбоо,
бөхчүүд, уяачид, харваачид,
иргэдээс ирүүлсэн
саналын нэгтгэл**

2025 он

ҮНДЭСНИЙ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬ-д

нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор аймаг, сум, байгууллага, мэргэжлийн холбоо, бөхчүүд, уяачид, харваачид, иргэдээс ирүүлсэн

саналын нэгтгэл

/40 гаруй байгууллага, 2000 орчим иргэдийн санал/

2025.03.31

ЕРӨНХИЙ НЭГ.

ӨГӨГДСӨН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ИРСЭН САНАЛУУД

Нэг:

Монголчууд өөрсдийн бахархал, түүх соёлоо дээдэлж, өвлүүлэхийн тулд Улсын баяр наадмаар бөхийн барилдаан, сур харваа, морины уралдаантай зэрэгцээ байдлаар “эрийн гурван наадам” (оролцогч бөхөө барилдаж, сураа харваж, өөрийн морио унаж уралддаг эртний хэлбэрийг сэргээх)-ыг сум болон аймгийн хэмжээнд хийдэг болох цаашид улсын хэмжээнд хийхээр төлөвлөх талаар:

1. 70.3 хувь нь дэмжсэн, 29,7 хувь нь дэмжээгүй;
2. Уламжлалаа сэргээж, Үндэсний их баяр наадмаар эртний эрийн гурван наадам хийх нь зүйтэй
3. Үндэсний их баяр наадмын үзэгч, сонирхогч өөрсдөө оролцох боломж олгож "Эрийн гурван наадам" гэдгийг давхар хийдэг байх нь зөв
4. Улсын баяр наадмаар оролцогч өөрөө барилдаж, сур харваж, морио унах нь одоо цагт нийцэхгүй тул дэмжихгүй
5. Сум болгон эрийн гурван наадам хийдэг байхаар хуульчлах, төсвийг нь хамт батлах

Хоёр:

Нүүдэлчдийн мартагдаж үл болох өв соёл, аж байдал, зан заншил, ахуйн онцлог харуулсан, бидний “Монгол” гэдэг дархлааг бий болгосон “Нүүдэлчдийн Монгол туургатны их наадам”-ыг 5 жил тутам нэг удаа бусад улс орны монгол угсаатнууд ирж оролцдог наадам байхаар зохион байгуулдаг болох;

1. 59.3 хувь нь дэмжсэн, 23.3 хувь нь Монгол дархлааг бий болгоход ач холбогдолтой, 13,5 хувь нь дэмжихгүй
2. "Нүүдэлчин фестиваль"-тай уялдуулан хамтад нь нэгдсэн байдлаар зохион байгуулж, ахуй соёлоо түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлах боломжийг бүрдүүлэх
3. Нүүдэлчдийн Монгол туургатны их наадам-ыг 5 жил тутамд хийдэг болгох хэрэгтэй
4. Монгол туургатны наадмыг 4 жилд 1 удаа тогтмол зохион байгуулах.

5. "Нүүдэлчин Монгол туургатны их наадам"-ыг бусад улс орны монгол угсаатнууд оролцдог нээлттэй наадам байх;
6. Нүүдэлчдийн Монгол туургатны их наадмыг 3-4 жил тутамд хийх;

Гурав:

Бөхийн эрэмбийн талаар;

1. Үндэсний бөхийн цолыг зөвхөн баяр наадамд барилдаж болзол хангасан бөхчүүдэд олгохоор тусгах, үүнтэй холбоотой Уяачид, сур харваачдын цолыг адилтгаж цол олгодог байхаар зохицуулах /Бүсийн наадмыг болиулах/;
2. Үндэсний бөхийн эрэмбийг гаргасан амжилтаар нь тодорхойлох, цол олгох асуудлыг зөвхөн улсын баяр наадмаар зохицуулдаг болох, мөн спортын болон үндэсний их баяр наадмын цолны эрэмбийг хуулиар нарийвчлан тодорхойлох;
3. Бөхийн цолны эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулна гэснийг хүчингүй болгож, баяр наадмын амжилтыг үндэслэн эрэмбийг тогтооно.
4. Үндэсний их баяр наадмын өмнө бүх аймгуудын баяр наадмыг зохион байгуулж байхаар тогтох түүнд амжилттай сайн барилдаж цол нэмсэн бөхчүүдийг шинэ цолтой нь Улсын их баяр наадамд барилдуулах
5. Аймгийн баяр наадамд Улсын цолтой бөх барилдуулахын хориглох
6. Бөхийн эрэмбийг амжилт, эсвэл оноогоор эрэмбэлэхийг шийдэж нэг талд нь гаргах хэрэгтэй
7. Монгол бөхийн эрэмбэ 2001 оноос өмнөх цолыг сэргээж, томоохон нэрэмжит барилдаанд эрэмбэнд оруулж дэвжээнд бүртгүүлэх
8. Одоогийн баримталж байгаа бөхийн эрэмбийг хэвээр үлдээх, Харин чансааны шаардлагатай. оноог боловсронгуй болгох
9. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагуу олгогдож буй бөхийн эрэмбийг хэвээр үлдээх,
10. Хэн түрүүлж цол авснаар нь эрэмбэлэх нь зөв байна.
11. Чанараар эрэмбэлж явах нь зүйтэй.
12. Дархан аварга түрүүлсэн тоогоор эрэмблэх.
13. Эрт үеэс уламжилж ирсэн эрэмбээр байх нь зүйтэй.
14. Одоогийн хуулиараа байх нь зөв.
15. Дархан аваргуудыг эрэмбэлэх нь буруу.
16. Зөвхөн улсын наадмын амжилтаар эрэмбэлэх.
17. Бөх, уяач, сур харваач, шагайн харваачийн эрэмбийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэг мөр хуульчлан тогтоох;

Дөрөв:

Допингийн шинжилгээ байх нь зөв эсэх талаар;

1. 73.8% тийм 16.5% үгүй 9.7% мэдэхгүй
2. Допингийн шинжилгээг тогтмол хийдэг байх зүйтэй
3. Допингийн шинжилгээ сар бүр авах хэрэгтэй
4. Допингийн шинжилгээ улирал болгон авдаг байх
5. Бөхчүүдийн допингийн шинжилгээг наадмаас өмнө авч барилдах эсэхийг нь шийдэх,

6. Улсын их баяр наадамд допингийн шинжилгээг 4 давсан бөхчүүдээс авах,
7. Аймгийн баяр наадамд 4 давсан бөхчүүдээс тогтмол авах;
8. Аймгийн баяр наадмын бөхийн барилдааны шөвгийн 4 бөхөөс допингийн шинжилгээ авдаг байх;
9. Аймаг, сумын баяр наадамд түрүүлж, үзүүлж, их шөвөгт шалгарсан бөхчүүдээс цол, эрэмбэ харгалзахгүй допингийн шинжилгээг тогтмол авдаг болох
10. Допингийн хүрээнд цол чимгийг хураах хугацааг хуулиар тогтоох, допингийн шинжилгээг дотооддоо авдаг, хариуг шуурхай мэдэгддэг нөхцөл боломжийг бүрдүүлэх, техник, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг зохицуулах;
11. Допингийн шинжилгээ авсан тохиолдолд хариу гарах хугацаанд шууд улсын цол тэмдэг олгох бус гэрчилгээ олгож, шинжилгээний хариу батлагдсаны дараа албан ёсоор цол тэмдгийг олгож, гардуулах арга хэмжээ авах;
12. Допингийн шинжилгээ авч харин 3 өдрийн дотор нийтэд зарлаж байх.
13. Допингийн шинжилгээг монгол улсад авдаг болох.
14. Аймгуудын баяр наадамд шөвгөрсөн бөхчүүдээс допингийн шинжилгээ авах
15. Допингийн шинжилгээний сорьц авах, хадгалах, тээвэрлэх, хариу ирэх үйл явцыг улам боловсронгуй болгож, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, шинжилгээний хариу богино хугацаанд гардаг болгох. Ямар нэгэн эргэлзээгүй баталгаатай байх.
16. Допинг илэрсэн тохиолдолд авах арга хэмжээ, шийтгэлийг тодорхой болгох.
17. Допингийн шинжилгээ авах, хадгалах, тээвэрлэх, хариу ирэх үйл явцыг илүү боловсронгуй болгох, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, шинжилгээний хариуг богино хугацаанд нээлттэй зарлах
18. Улсын баяр наадмаар барилдаж буй бөхчүүдээс Допингийн шинжилгээ авч, шинжлэх үйл явцыг түргэсгэх, хариуг ил тод олон нийтэд мэдээлэх
19. Бөх, сур харваач, шагайн харваач нараас болон улс, аймаг, бүсийн наадамд айрагдсан хурдан мориноос заавал допингийн шинжилгээ авч байх;
20. Үндэсний бөхийн барилдааныг үнэнч, зөв, шударга байлгах үүднээс допингийн шинжилгээг тогтмолжуулж түүнд ногдуулах хариуцлагын тогтолцоог хуульчилж өгөх
21. Допингийг нарийн тодорхой байлгах, мөн хэрэглэж байгаа хоол хүнс нь нөлөөлдөг эсэхийг тодруулдаг байх
22. Допингийн шинжилгээг 24 цагийн дотор гаргадаг байх зохицуулалт хийх,

Тав:

Улсын баяр наадмаар 10 хоног амардаг байх талаар;

1. Улсын баяр наадмын амралтыг нэмэх нь зөв
2. Улсын баяр наадмаар 10 хоног амардаг байхыг дэмжиж байна.
3. Улсын баяр наадмаар 10 хоног амрах саналыг дэмжижгүй байна, хэт олон хоног байна.
4. Улсын баяр наадмаар ажлын 5 хоног амрах нь зөв
5. Улсын баяр наадмаар 5 хоног амрах нь зөв
6. Сур харвааны төрлүүд 7-р сарын 06-аас эхэлдэг тул, баяр наадмын албан ёсны амралтын өдрүүдийг 7-р сарын 05-наас 15-ыг хүртэл 10 хоног амардаг байх саналуудыг хүргүүлж байна

7. Үндэсний баяр наадам, Цагаан сар хоёроор 10 хоног амардаг. Бусад бүх нийтийн амралт шаардлагагүй гэж харж байна.
8. Улсын баяр наадмаар 5, Цагаан сараар 5 хоног амардаг байх хэрэгтэй.
9. Улсын баяр наадам, цагаан сараар тус бүр ажлын 5 хоног амардаг байх хэрэгтэй.
10. Улсын баяр наадмаар 7 сарын 10-15-ныг хүртэл 5 хоног амрахад болно. Зун хүмүүсийн амралт эхэлсэн байдаг учраас 5 хоног амрахад болно.
11. Наадмаар 7 хоног байхад л болно, Хэт олон хоног байх шаардлагагүй.
12. Баяр наадмын амралтыг ажлын хоногоор тооцон хуульчлах

Зургаа:

Уяачид, сур харваачдын цолыг бөхтэй адилтгах талаар;

1. Уяачид, сур харваачдын цолыг бөхтэй адилтгах талаар 73,7 хувь нь дэмжсэн, 26,3 хувь нь дэмжээгүй
2. Уяачид, сур харваачдын цолыг бөхтэй адилтгаж олгох нь маш зөв
3. Баяр наадмын төрлүүдийн цолыг адилтган олгох, аймгийн цолыг улсын цолтой адилтгах, үндэсний спортын их наадмын түрүү харваачийн цолыг хуулинд тусгах, сурын харвааны улсын баяр наадмын шигшээ 32, 16-д шөвгөрсөн харваачдад чимэг олгох, сумын баяр наадмын сур харвааны төрлийг улстай адилхан 5 байраар цол олгох,
4. Хурдан морь уяачдын амжилтыг бөхчүүдийнхтэй адилтгаж (devjee.mn шиг адил зохицуулалтаар) бүртгэлжүүлэх;
5. Шаардлагагүй
6. Уяачид, сур харваачдын цолыг бөхтэй адилтгах талаар саналыг уяачид дэмжихгүй байна
7. Уяачид, сур харваачдын цолыг бөхтэй адилтгахыг дэмжихгүй
8. Уяачид, сур харваачдын төдийгүй шагайн харваачдын цолыг бөхтэй адилтгах хэрэгтэй;

Долоо:

Бөхийн цолд бүсийн цол нэмэх талаар

1. Бөхийн цолд бүсийн цол нэмэх талаар 54.7 хувь нь дэмжихгүй, 45,3 хувь дэмжсэн
2. Бүсийн цол нэмэхийг дэмжихгүй;
3. Бүсийн цол олгодог болвол эрэмбийг маш нарийвчлан хуулиар зохицуулах;

ЕРӨНХИЙ ХОЁР. НЭМЭЛТЭЭР ИРСЭН БУСАД САНАЛУУД

Нэг. Цол олголтын холбоотой санал:

1. Сум, аймаг, улсын цолыг дарааллаар олгодог болох
2. Цолны босго өндөр болгох.
3. Сумдын 10 жилийн алхамтай тэгш ойг Аймгийн баяр наадмын амжилттай дүйцүүлэн цолны амжилтад тооцох
4. Үндэсний бөх, хурдан морь, сур харваа, шагайн харваа бүгд адилхан төрийн наадмын амжилтаараа цол авдаг байх.
5. Засгийн газрын тогтоолтой бүсийн наадамд бөх, сурын харваанд цол олгодог болох
6. Сум, аймаг, улсын цолнуудын залааны ялгааг тодотгож, нэг журамд оруулах;
7. Бөх морь, шагай, сурын харваа зэргийн сумын цолонд залаа чимэг өгдөггүй байх. Аймгийн цолонд хүрч байж залаа зүүдэг байсан хуучин заалт сэргээх.
8. Гадаадад байгаа монголчуудад цол олгохыг хуульчлах, цолоо дүйцүүлэн монголдоо ирж наадамд оролцох нөхцөлийг дэмжих

Хоёр. Бөхийн цолны холбоотой санал:

1. Бөхийн барилдаанд шөвгөрсөн 32 бөхөд цол чимэг олгодог. Хэдэн ч морь уралдсан 5 морьдыг барьдаг тул морины амжилтыг бүсээр тооцож, бөхийн амжилтыг зөвхөн улсын баяр наадмаар тооцох нь зөв,
2. Харцага, гарьд цол хэрэггүй.
3. Бөхийн тойргийн цолыг тооцохгүй байх, тойргийн цолыг олгохгүй байх
4. Тойргийн барилдааны цолыг сэргээх
5. Тосгоны наадамд бөхийн цол олгодог болох
6. Бөхийн цолны эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулна гэснийг хүчингүй болгох, /Баяр наадмын амжилтыг үндэслэн эрэмбийг тогтооно./
7. Үндэсний их баяр наадмын өмнө бүх аймгуудын баяр наадмыг зохион байгуулж байхаар тогтох түүнд амжилттай сайн барилдаж цол авсан бөхчүүдийг шинэ цолтой нь Улсын их баяр наадамд барилдуулах
8. Аймгийн баяр наадамд Улсын цолтой бөх барилдуулахыг хориглох
9. Тойргын цолтой барилдаж байсан хүмүүсийн цолыг сэргээх хэрэгтэй. Хууль баталсанаас хойшхи тойргын цолыг хураах:
10. Сумын баяр наадамд цолны болзол хангаагүй бөхөд хуурамч цолны үнэмлэх олгож байгаа сумын Засаг дарга болон тухайн бөхөд хариуцлага тооцдог байх.
11. Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх зэрэг дүүргүүдэд цол олгох барилдаан хийхийг хориглох
12. Үндэсний бөхийн цолыг зөвхөн баяр наадамд барилдаж болзол хангасан бөхчүүдэд олгохоор тусгах үүнтэй холбоотой Уяачид, сур харваачдын цолыг адилтгаж цол олгодог байхаар зохицуулах /Бүсийн наадмыг болиулах/

13. 2021 онд зохион байгуулагдсан Залуучуудын холбооны 100 жилийн ойд зориулсан 512 бөхийн барилдаанд барилдаж шөвгөрч, үзүүрлэж, түрүүлсэн бөхчүүдэд цолыг нь нехен олгох
14. Бөхийн барилдаанд 10 давж түрүүлсэн бөхөд аварга цол олгодогтой адил Сурын харваанд сум алдалгүй Үндэсний сурд 40, Урианхай сурд 30, Буриад сурд 64 онож/түрүүлсэн бол Улсын мэргэн болон дараачийн цолыг шууд олгодог болох
15. Хилийн гадна болж байгаа наадмуудын барилдааныг цолтой болгох

Гурав. Уяачдын цолны холбоотой санал:

1. Орон нутаг буюу аймаг сумдын наадамд тогтмол оролцож "Аймгийн алдарт уяач" цолны болзлыг хангаж, уг амжилтаа 2-3 удаа давуулсан уяач нарт "Аймгийн манлай уяач" цол зэрэг олгох;
2. Дархан тод манлай цолыг шинээр бий болгох;
3. Сэрвээний өндөр болон нас өгсүүлэх буюу бууруулж морь уралдуулсан уяачид. морины комиссын гишүүдэд хариуцлага тооцдог байх, зөрчил гаргасан уяачдын цолыг хураах, цаашид дээрх хүний нэр дээр уралдсан морьдын амжилтыг тооцдоггүй байх
4. Монгол-6, сонгомол-3 нийт 9 насны морь уралддаг. Энэ морьдын байр эзэлснээр цолыг өгдөг. 12 айраг, 6 түрүү: Аймгийн алдарт, 12 айраг 8 түрүү: Сумын алдарт буюу 2022 оны Үндэсний баяр наадмын тухай шинэчилэн найруулсан 10.5-заалтын дагуу цолоо өгөх
5. Аймагт манлай уяач цол байх хэрэгтэй байна.
6. Сонгомол ангиллын уралдааны амжилтыг улс, аймаг, сумын цол олгох амжилтад оруулахгүй байх.
7. Жороо морины уралдааныг сэргээх
8. Морины цолыг зөвхөн наадмын амжилтаар олгодог болох, тэгэхдээ цол олгох босгоо багасгаж болно гэсэн саналтай байна.
9. Эрлийз морины төрлийг хасах, амжилтыг цолд тооцохгүй байх;
10. Сумын алдарт уяач цол тэмдэг олгохтой холбоотой асуудлыг нарийвчлан тогтоох;

Дөрөв. Харваачдын цолны холбоотой санал:

1. Сур харваачдын аймгийн цолыг түрүүгээр нь эрэмбэлдэг байх,
2. Үндэсний сурын цолтнуудыг улсын цолтон, аймгийн цолтон, сумын цолтон, спортын мастер, дэд мастер, спортын 1-3 дугаар зэрэгтнүүд болон залуу харваачид гэж эрэмбэлдэг байхаар тусгаж өгөх
3. "Үндэсний сурын харвааг цуваа харваагаар явуулна" гэснийг Үндэсний их баяр наадмын сурын харвааг их сур, урианхай сур, буриад сурын цуваа харвааны төрлүүдээр зохион байгуулна. Улс, аймаг, сумын баяр наадмын сурын харвааны төрлүүдэд /их сур, урианхай сур, буриад сур/түрүүлж айрагдсан харваачдад тухайн сурын харвааны дүрэмд заасан цолыг Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг болон аймаг, сумын засаг даргын захирамжаар олгоно;

4. "Улсын баяр наадмын үндэсний сурын харваанд гуравдугаар байр эзэлсэн харваачид улсын гоц харваач, хоёрдугаар байр эзэлсэн харваачид улсын гарамгай харваач, нэг түрүүлсэн харваачид улсын мэргэн, улсын мэргэн цолтон түрүүлбэл улсын даян мэргэн, улсын даян мэргэн цолтон түрүүлбэл улсын даяар дуурьсах мэргэн, улсын даяар дуурьсах мэргэн цолтон түрүүлбэл улсын дархан мэргэн цол олгоно" гэснийг Улсын баяр наадмын их сурын харваанд 4,5-р байр эзэлсэн харваачдад ерөнхийлөгчийн зарлигаар Онч, Тод харваач цол олгох, шилдэг 16-д шалгарч, үлдсэн 11 харваачдад мөнгөн шагнал олгох. Эхний 5 байранд орсон харваачдын мөнгөн шагналыг сурын харвааны төрөл тус бүрд ижил тэнцүү болгох;
5. Улс, аймаг, сумын баяр наадмын үндэсний их сур, буриад, урианхай сурын харваанд байр эзэлсэн харваачид цолыг Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг болон аймаг, сумын засаг даргын захирамжаар олгоно.-гэж нэгтгэсэн нэмэлт өөрчлөлт оруулах.
6. Улсын баяр наадмын Урианхай сурын харваанд түрүүлсэн харваачид Урианхай сурын Улсын мэргэн цол, хоёр дахь удаагаа түрүүлбэл Урианхай сурын улсын Хошой мэргэн, гурав дахь удаагаа түрүүлбэл Урианхай сурын Улсын дархан мэргэн, дөрөв дэх удаагаа түрүүлбэл Урианхай сурын Улсын Эрхий мэргэ цол тус тус олгоно гэж тусгуулах
7. Улсын баяр наадмын Үндэсний сурын хүүхдийн харваанд түрүүлсэн өсвөрийн харваачид улсын идэр мэргэн цол, хоёр дахь удаагаа түрүүлбэл улсын өсөх идэр мэргэн цол тус тус олгоно гэж тусгуулах,
8. Улсын баяр наадамд эхний 5 байранд орсон харваачдад цол зэрэг олгодог бөгөөд 2022 оноос өмнө 4-р байр улсын онч харваач, 5-р байр улсын тод харваач цолны болзол биелүүлсэн харваачдад цолыг нөхөн олгуулах;
9. Сур харваачид үндэсний их баяр наадмын хуулиараа цолоо авдаг. Хавтгайруулах шаардлагагүй.
10. Бөхийн барилдаанд 10 давж түрүүлсэн бөхөд аварга цол олгодогтой адил Сурын харваанд сум алдалгүй Үндэсний сурд 40, Урианхай сурд 30, Буриад сурд 64 онож түрүүлсэн бол Улсын мэргэн болон дараачийн цолыг шууд олгодог болох,
- 11.
12. Аймаг сумын баяр наадмын урианхай, буриад сурын харвааны төрлүүдэд эхний таван байранд орсон харваачдад аймаг, сумын засаг даргын захирамжаар тухайн харвааны дүрэмд заасан цол олгох.
13. Сурын харваанд аймгийн цолтой хүнд спортын цол давхар олгодог тогтолцоог болиулах
14. Аймгийн баяр наадмын Үндэсний сурын хүүхдийн харваанд түрүүлсэн өсвөрийн харваачид аймгийн идэр мэргэн цол, хоёр дахь удаагаа түрүүлбэл өсөх идэр мэргэн цолыг нь аймгийн Засаг даргын захирамжаар тус тус олгоно гэж тусгуулах,
15. Аймгийн баяр наадмын буриад сурын харваанд түрүүлсэн харваачид аймгийн мэргэн, 2-р байр эзэлсэн харваачид аймгийн гарамгай харваач, 3-р байр

- эзэлсэн харваачид аймгийн гоц харваач, 4-р байр эзэлсэн харваачид онч харваач, 5-р байр эзэлсэн харваачид тод харваач цол олгох
16. "Аймаг, сумын баяр наадмын үндэсний сурын харваанд түрүүлсэн харваачид аймаг, сумын мэргэн, хоёрдугаар байр эзэлсэн харваачид аймаг, сумын гарамгай харваач, гуравдугаар байр эзэлсэн харваачид аймаг, сумын гоц харваач цол олгоно" гэснийг Аймаг сумын баяр наадмын их сурын харвааны эхний таван байранд орсон харваачдад аймаг, сумын засаг даргын захирамжаар түрүүлсэн харваачид аймаг, сумын мэргэн, хоёрдугаар байр эзэлсэн харваачид аймаг, сумын гарамгай харваач, гуравдугаар байр эзэлсэн харваачид аймаг, сумын гоц харваач, дөрөвдүгээр байр эзэлсэн харваачид аймгийн Онч харваач, тавдугаар байр эзэлсэн харваачид аймгийн Тод харваач цол олгох
17. Сумын баяр наадмын буриад сурын харваанд 3-р байр эзэлсэн харваачид сумын гоц харваач, 2-р байр эзэлсэн харваачид сумын гарамгай харваач, түрүүлсэн харваачид сумын мэргэн цол олгоно
18. Сумын баяр наадмын Буриад сурын харваанд түрүүлсэн харваачид Буриад сурын сумын мэргэн цол, Буриад сурын сумын мэргэн цолтон хоёр дахь удаагаа түрүүлбэл Буриад сурын сумын хошой мэргэн цол, гурав дахь удаагаа түрүүлбэл Буриад сурын сумын Хүйхэрэй мэргэн цол, дөрөв дэх удаагаа түрүүлбэл Буриад сурын сумын мэргэн цолыг сумын Засаг даргын захирамжаар тус тус олгоно гэж тусгуулах
19. Сумын баяр наадмын Үндэсний сурын хүүхдийн харваанд түрүүлсэн өсвөрийн харваачид сумын идэр мэргэн цол, хоёр дахь удаагаа түрүүлбэл өсөх идэр мэргэн цолыг сумын Засаг даргын захирамжаар тус тус олгоно гэж тусгуулах,

Тав. Сурын харваатай холбоотой санал

1. Сурын бай шагналыг бусад төрөлтэй адил болгох.
2. Сур харвааны талбайг тухайн аймаг, сумын өмчид оруулах, улсын сур харвааны талбайг төрийн өмч болгох, мөн улсын баяр наадмын сурын талбайг 1000, 2000 харваач харвах нөхцөл боломжоор хангах;
3. Улс, аймаг, сумын баяр наадамд өрсөлдөх сурын харваачдын тоог үндэсний бөхтэй адилтгаж, хуулиар тогтоох;
4. Улсын баяр наадмаар ганцаарчилсан төрөл буюу цуваа харвааг нэмэлтээр оруулах хүсэлтэй байна.
5. Харваачдын харвах наадах орчин нөхцөлийг бүрдүүлэх, дэмжих.
6. Сонирхогчдын сур харвааг жил бүр зохион байгуулах
7. Улс аймаг сумын наадамд оролцох харваачдын тоог бөхчүүдийн тоотой адил дээд хязгаартай болгох.

Зургаа. Морин уралдаантай холбоотой санал:

1. Үндэсний их баяр наадмаар 6 насны морьд уралдуулах, тэдгээрийг сэрвээний өндрөөр хэмжиж уралдуулах асуудлыг хуульд тусгах,
2. Шүдлэн насны морьдын сэрвээний өндрийг одоо мөрдөж байгаагаас 2 сантиметрээр нэмэгдүүлэх,
3. Айрагдаж түрүүлсэн морьдын сэрвээний өндрийг дахин хэмждэг байх.
4. Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааныг сэрвээний өндрөөр хэмжиж уралдах нь зөв.
5. Уралдаанд оролцох морьдыг үүлдэрлэг байдлаар ялгах
6. Сэрвээний өндөр хэмжих тоног төхөөрөмжийг боловсронгуй болгох
7. Монгол адуугаараа л уралдах хэрэгтэй
8. Морин уралдааны тоог ceелeх
9. Морины чансааг сайжруулах, зөвхөн монгол морио уяж уралдуулах, эрлийз морио тусад нь уралдуулах
10. Хаврын Дүнжингарав уралдааныг хаах гээд улс даяараа багахан уралдаан сунгааг хааснаа эргэж харах. Хөдөөд уралдаануудыг нээж өгөх.
11. Дүнжингарав хаврын морин уралдааныг сэргээх нь чухал.
12. Хурдан морийг хэмжилтийн өндрөөр биш үүлдэр угсаагаар нь уралдуулдаг байх.
13. хөдөөний монгол морины уралдаангүй болж байна, үүнд анхаарах.
14. Хаврын уралдааныг сэргээх 3 сарын 1-нд болгох
15. Хурдан мориний сэрвээний өндрийг 2см-р багасгаж уралдуурах
16. Түүнчлэн эрлийз морийг сум, аймаг төдийгүй Үндэсний их баяр наадмаар уралдуулж байгаа нь "Үндэсний их баяр наадам"-ын агуулгад нийцэхгүй байх тул монгол болон эрлийз морийг ялган уралдуулах зохицуулалтыг нарийн тусгах шаардлагатай талаар нэмэлт санал гарсан байна
17. Шүдлэн насны морьдын сэрвээний өндрийг одоо мөрдөж байгаагаас 2 сантиметрээр нэмэгдүүлэх
18. Хурдан мориноос допингийн шинжилгээ авдаг болох,
19. хурдан морины уралдаанд эрлийз морь уралдуулахгүй байх
20. Үндэсний их баяр наадмын үеэр Монгол морины генийг нарийвчлан хурдан хугацаанд тогтоох шинжилгээг явуулдаг, түүгээр шинжилж уралдуулаг байх,

Долоо. Шагайн харваатай холбоотой гарсан саналууд:

1. Шагайн харвааны улсын аваргаар цол олгох хэрэгтэй.
2. Шагайн харвааны цолийг, аймгийн цолыг нэмэх
3. Шагай харвааг сур харвааны цолтой адилтгахгүй байх
4. Шагайн харвааг сур харваатай адил түвшинд авч үзэж байх
5. Шагайн харваанд хувийн цуваа харвааг оруулж цол олгодог болгох
6. Шагайн харвааг илүү дэмжиж хөгжүүлэх. Бай шагнал урамшууллыг өндөр болгож, бөх, морьтой адил бай шагнал урамшуулал олгох.
7. Уяачид, сур харваачид бөхтэй шагайн харваачдын цолыг адилтгах

8. Үндэсний шагайн харваан тэмцээний хувьд суманд 3 удаа байр эзэлсэн бол сумын мэргэн цол олгодог байх
9. Шагайн харвааны төрөлд хувийн цуваа харвааг явуулдаг болгох.
10. Шагайн харвааны цолыг аймгийн хэмжээнд олгодог болгох мөн улсын баяр наадамд ганцаар буюу цуваа харваанд улсын цол олгодог болгох.
11. Шагайн харвааны төрөлд улсын баяр наадмаар ганцаарчилсан төрөл оруулах.
12. Шагайн харвааг бөх, уяач, сур харваатай адилтгах, шагайн харвааны хувийн цуваа харвааг үндэсний баяр наадамд оруулах цол олгодог болох.
13. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 12.1 үндэсний шагайн харвааг багийн харваагаар явуул гэсэн заалтад үндэсний шагайн харвааг багийн болон хувийн цуваа харваагаар явуулах мөн хувийн цуваа харваанд аймаг улсын цол олгодог болох.
14. Сумдын баяр наадамд шагайн харвааны өөр цол чимэг олгох.
15. Үндэсний шагайн харваанд шагайн болон багийн ба цуваа харваанд оруулах.

Найм. Наадмын цаг хугацааны талаар:

1. Монголчуудын бахархал болсон түүх соёл, өв уламжлалаа дээдлэн өвлүүлэх, сурталчлан таниулах Улсын баяр наадмыг аймаг, сумын хэмжээнд цаг хугацааны хувьд зэрэг хийдэг болох,
2. Аймаг, сумын баяр наадмыг 7 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ" гэснийг аймаг, сумын баяр наадмыг 10-11-ны хооронд гэснийг өөрчилж 7 дугаар сарын 09-нд тэмдэглэж дууссан байхаар тогтоох /аймаг, сумандаа барилдсан, уралдсан, харвасан бөхчүүд, харваачид, уяачид улсын наадамд боломжийг олгох/;
3. Бүсийн болон тэгш ой давхацсан аймгуудын баяр наадмаас бусад аймгуудын наадмыг Улсын баяр наадамтай нэг өдөр зохион байгуулдаг болгох
4. Аймаг, сумын наадмыг зохион байгуулах хугацаа нэг дор байгаа нь аймаг сумдад бөх, морь, харваач цеен оролцох, ор нэр төдий болох байдал цаашид бий болох сөрөг үр дүн гарах магдлалтай. Иймд сумыг 7-н сарын 2-3 хооронд, аймгийн наадмуудыг 10-11-нд хийх нь зөв. Сумандаа сайн уралдсан морь, сайн барилдсан бөх аймагтаа ирж цол зэргээ ахиулах боломжтой.
5. Сум, аймаг, улс 7.11-13 ныг дуустал наадмаа хийдэг байх. Цуварч өөр өөр хугацаанд хийдэг байдлыг болиулах, зохион байгуулалтын талаар маш сайн хуульчилж өгөх
6. Монголынхоо өв уламжлалаа хадгалж орон даяар зэрэг наадмаа хийдэг болж хэвших. 7 сардаа бүх сумдууд 1 өдөр. Дараа нь 21 аймаг 1 өдөр, сүүлд нь улс наадмаа хийж байх
7. Бүх аймгийн баяруудыг нэг өдөр хийдэг байх хэрэгтэй.

8. Сумдын баяр наадмыг нэгэн зэрэг 07 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх, Сумын баяр наадмын бөхийн барилдааныг нэг өдөр зэрэг эхлүүлдэг болох.

Ес. Бай шагналтай холбоотой санал:

1. Эрийн 3 наадмын түрүү бай бүгд адил тэгш байх. Сур, морь, бөх 3-н бай шагналыг ижил байлгах.
2. Морь, бөх, сурын харваа болох эрийн гурван наамдыг ижил тэнцүү байлах нь зүйтэй
3. Баяр наадмын төрлүүдийн бай шагналыг ижил түвшинд болгож, адилтгах;
4. Сур харвааны бай шагналыг үндэсний бөхийн бай шагналтай адилтгах
5. Улсын баяр наадмын шигшээ харваанд шалгарч үлдээд 6-16-р байранд орсон харваачдад /сурын төрөл тус бүрд/ мөнгөн шагнал олгодог болох
6. Улсын баяр наадмын шигшээ харваанд шалгарч үлдээд 6-16-р байранд орсон харваачдад /сурын төрөл тус бүрд/ мөнгөн шагнал олгодог болох
7. Эхний 5 байранд орсон харваачдын мөнгөн шагналыг сурын харвааны төрөл тус бүрд ижил тэнцүү болгох

Арав. Наадмын зохион байгуулалтын холбоотой санал:

1. Сум бүр Үндэсний Их баяр наадмыг заавал тэмдэглэж байхаар хуульчлах /аймгийн төвийн сумдууд баяр наадмаа хийдэггүй тул дээрх байдлаар хуулинд тусгах/
2. Чанартай том хэдэн нааддаг болох хэрэгтэй.
3. Эрийн гурван наадмын утга учир алдагдахгүй байх нь л чухал.
4. 21 аймгаар эсвэл боломжит аймгуудаар тойрч улсын баяр наадам хийх.
5. Улсын баяр наадам, цагаан сараар л өв соёл, уламжлалаа түгээн дэлгэрүүлсэн олон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, бага насны хүүхдээс эхлээд бүх хүмүүст тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол улсын иргэн гэдгийг ой тоонд нь ортол нь ойлгуулж, уламжлалт арга, өв соёлыг бүр багаас нь эзэмшүүлж сургах хэрэгтэй.
6. Баяр наадмаар архи заруулахгүй байхыг хуульчлах
7. Наадмыг зөв зохистой, үнэн зөв хийх. Найраагаа зогсоох, шударга байх хэрэгтэй.
8. Улсын баяр наадмаар сум бүр эрийн 3 наадмыг /бөхийн барилдаан, сурын харваа, морины уралдаан/ ижил тэнцүү байдлаар /бай шагнал/зохион байгуулах,
9. Сум бүр Үндэсний Их баяр наадмыг заавал тэмдэглэж байхаар хуульчлах /аймгийн төвийн сумдууд баяр наадмаа хийдэггүй/
10. Сум, аймгийн баяр наадмын бөхийн барилдааны тоог заахгүй байх, харцага цолыг хэвээр үлдээх,
11. Монгол туургатан хүмүүс баяр наадамд оролцох нөхцөл бүрдүүлэх.

12. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.19, 10.20 дахь хэсгүүдийг хасах; /10.19.Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно. 10.20.Энэ хуулийн 10.19-д заасан жороо морины уралдаанд морио уяж, уралдуулсан уяачийн амжилт нь энэ хуулийн 10.4, 10.5, 10.6-д заасан болзлыг хангасан бол уяачид мөн хэсэгт заасан цолыг олгоно. /Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./
13. Баяр наадмын төрлүүдийг чансаатай, чанартай байх талд анхаарч зохицуулалт оруулах;
14. Үндэсний их баяр наадмын хүрээнд сум, аймгийн баяр наадамд хүний эрхийг дээдэлсэн, нутаг усны үзэл хандлага гарахгүй байхад анхаарч зохицуулалт оруулах;
15. Улсын баяр наадмаас бусад жижиг баяр наадамд медаль олгодог байдлыг халах хэрэгтэй. Медалийг үнэ цэнтэй болгох хэрэгтэй.
16. Эрийн 3-н наадмаар гадаад хүн оролцох эсэхийг эцсийн байдлаар шийдэх.
17. Баяр наадмаар үзэж харах юм нэмэх, Жишээ нь: Морьтой үзүүлбэр, дэмбээ зэрэг
18. Морь бөх цоллоочдыг урамшуулдаг тогтмол урамшуулал, цалин хөлстэй болгох
19. Наадам ард түмний наадам биш мөнгөтэй төрийн хулгайч нарын зиндаархал болсоныг болиулах.

Арван нэг. Бусад санал

1. Төрийн наадмын бай шагналыг нэмэгдүүлэх
2. Сум аймгийн баяр наадам зохион байгуулах төсвийг яаралтай нэмэгдүүлэх.
3. Насанд хүрээгүй хүүхэд болон өөрөө гардаж уяагүй уяач, эмэгтэй хүний нэр дээр морь мордуулахгүй байх
4. Аймаг, суманд Улсын баяр наадмын 3 харваа (Их сур. Буриад сур. Урианхай сур)-г оруулах
5. Бөх, уяач, сур харваач, шагайн харваачийн эрэмбийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэг мөр хуульчлан тогтоох;
6. Аймаг сумдын баяр наадмын зардал 5,000,000 төгрөгийг сумдад нэмэгдүүлэх,
7. уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой заалт оруулах,
8. Хурдан морины уралдаанч хүүхдийг урамшуулах асуудлыг хуулинд тусгаж өгөх /Улс, аймаг, сумын баяр наадамд айрагдсан амжилтаар нь.
9. Хурдан морь унадаг унаач хүүхдүүдийг тусгайлан бэлтгэх.
10. Уралдаанч хүүхдийн хувцас хэрэглэлийг хуульд тодорхой зааж өгөх, хэрэгжилтийг тусгаж өгөх.
11. Ес бус үйлдэл гаргасан бөх, уяач, харваачдад хариуцлага тооцдог болох хэрэгтэй
12. Хурдан морь болон үндэсний бөх цоллооч нарын асуудлыг хуульд тусгах